




Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага

БАЯНХОНГОР, ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАЛУУЧУУДЫН ОРЛОГЫН БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

ОУХБ/Япон Улсын Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжүүлсэн “Монгол Улсад нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих, АСЕАН-ы туршлагаас суралцах нь төсөл”



2016



ОУХБ/Японы
Олон-хоёр талт хамтын
ажиллагааны хөтөлбөр

БАЯНХОНГОР, ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАЛУУЧУУДЫН ОРЛОГЫН БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

ОУХБ/Япон Улсын Засгийн газрын дэмжлэгтэй
хэрэгжүүлсэн “Монгол Улсад нийгмийн хамгаалал,
хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих, АСЕАН-ы
туршлагаас суралцах нь төсөл”



Зохиогчийн эрх © Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 2016

2016 онд анх удаа хэвлэгдэв.

Олон улсын хөдөлмөрийн товчооны хэвлэл нийтлэл нь Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенцийн 2 дугаар Протоколд заасны дагуу зохиогчийн эрх эдэлнэ. Гэвч эх сурвалжийг нь дурдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр тэдгээрээс иш татан ашиглаж болно. Дахин хэвлэх буюу орчуулах эрхийг авахын тулд ОУХТ-ны Хэвлэл нийтлэлийн албанд (Эрх,зөвшөөрөл) ILO Publications, International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland гэсэн хаягаар, эсвэл rights@ilo.org гэсэн цахим шуудангаар хандана уу.

Хуулбарлах эрхийн байгууллагуудад бүртгэлтэй номын сан, байгууллага болон бусад хэрэглэгчид тэдэнд олгогдсон зөвшөөрлийн дагуу номыг олшруулж болно. Танай улсад буй хуулбарлах эрхийн байгууллагын талаар www.ifrro.org хаягаар мэдээлэл авна уу.

ILO Cataloguing in Publication Data

Баянхонгор, Өвөрхангай аймгийн залуучуудын орлогын баталгааг сайжруулах туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан / Олон улсын хөдөлмөрийн байгууллага, ОУХБ-ын БНХАУ, Монгол улсыг хариуцсан товчоо. - Бээжин: ОУХБ, 2016.

ISBN: 9789228312508; 9789228312515 (web pdf)

Олон улсын хөдөлмөрийн байгууллага; ОУХБ-ын БНХАУ, Монгол улсыг хариуцсан товчоо.

young worker / rural youth / pastoralism / agricultural worker / social protection / household income / livelihoods / regional level / Mongolia

14.02.2

Англи хэл дээрх хувилбарыг дараах хаягаар орж үзнэ үү: *Technical report of the pilot programme for increasing income security of rural youth in Bayankhongor and Uvurkhangaï aimags of Mongolia* / International Labour Organization, ILO Country office for China and Mongolia (ISBN 978-92-2-131052-5; 978-92-2-131053-2 (web pdf), Beijing: ILO, 2016

Нэгдсэн үндэстний байгууллагын практикт нийцүүлэн гаргадаг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хэвлэл нийтлэлд Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс аливаа улс орон, бүс, газар нутгийн болон эрх барих байгууллагын эрх зүйн байдал, эсвэл тэдгээрийн хил хязгаарыг тогтоохтой холбоотой ямарваа нэг үзэл бодол илэрхийлдэггүй болно.

Зохиогчтой өгүүлэл, судалгаа болон бусад нийтлэлд илэрхийлэгдсэн үзэл бодлын талаарх хариуцлагыг гагцхүү тэдгээрийг зохиогч хүлээх бөгөөд Олон улсын хөдөлмөрийн товчоо хэвлэн нийтэлсэн нь тэдгээрт илэрхийлсэн үзэл бодлыг зөвшөөрсөн хэрэг биш юм.

Фирмийн нэр болон арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, технологийн үйл явцын талаар дурдсан нь Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс тэдгээрийг сайшааж байгааг илэрхийлэхгүй бөгөөд тодорхой фирм, арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, технологийн үйл явцыг дурдалгүй орхигдуулсан бол энэ нь тэдгээрийг үгүйсгэсэн явдал биш болно.

ОУХБ-ын хэвлэл нийтлэл болон цахим бүтээгдэхүүнүүдийг томоохон номын худалдаа, эсвэл цахим мэдээллийн сангаас авах буюу ilo@turpin-distribution.com гэсэн и-мэйлээр шууд захиалан авч болно. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.ilo.org/publns вэб сайт, ilorubs@ilo.org-мэйл хаягаар холбогдоно уу.

Монгол Улсад хэвлэв.

Энэхүү тайланг ОУХБ/Япон Улсын Засгийн газраас хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсад нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих, АСЕАН-ы туршлагаас суралцах нь төсөл”-ийн Ахлах зөвлөх Селин Пейрон Бистагийн удирдлага дор үндэсний зөвлөх Н.Монголмаа бэлтгэлээ. Тайланг боловсруулахад тус төслийн Хөтөлбөрийн ажилтан Ё.Нямдаваа, төслийн Үндэсний менежер А.Лхагвадэмбэрэл, ОУХБ-ын Бээжин дэх товчооны Хөтөлбөрийн шинжээч Париссара Люкит, ОУХБ-ын Зүүн өмнөд Ази, номхон далайн бүсийн Зохистой хөдөлмөрийн багийн Ур чадвар, хөдөлмөр эрхлэлтийн чадамжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Кармела Торрес нар санал бодлоо харамгүй хуваалцсанд талархаж байна. Төслийн хэрэгжилтийн явцад шуурхай удирдлагаар хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажилласан ОУХБ-ын БНХАУ, Монгол Улсыг хариуцсан товчооны захирал Тим Дэ Мэйэрт талархсанаа илэрхийлье.

МАПС төслийн багийн зүгээс туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, хамтран ажилласан орон нутгийн удирдлага, ажилтнууд, малчдын хоршоод, ялангуяа Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Засаг дарга О.Түмэнжаргал, Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга С.Баттулга нарт мөн талархаж буйгаа илэрхийлье. Түүнчлэн туршилтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлсэн Хөдөлмөрийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, ОУХБ-ын Хоршооллын асуудал хариуцсан хэлтсийн дарга Симел Эсим, ОУХБ-ын Монгол дахь Үндэсний зохицуулагч П.Болормаа нарт талархал илэрхийлэхийг хүсч байна. Эцэст нь төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Япон Улсын Засгийн газарт онцгойлон талархаж буйгаа уламжилъя.

АГУУЛГА

Хураангуй.....	vii
Товчилсон үгийн жагсаалт.....	xi
Удиртгал.....	1
Ерөнхий мэдээлэл.....	1
Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд.....	3
Туршилтын хөтөлбөрийн стратеги, үйл ажиллагаа.....	4
Туршилтын хөтөлбөрийн гол үр дүн.....	7
Малчид, орон нутгийн иргэдэд бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ бий болов.....	7
Бүтээмжтэй хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа тэтгэхийн төлөө залуу малчдын ур чадварыг хөгжүүлэв.....	9
Ирээдүйгээ харахуй: Малчдын амьжиргааг дээшлүүлэхэд хоршооны гүйцэтгэх үүрэг.....	13
Хөдөөгийн залуучуудын ур чадвар, орлогын баталгааг дэмжихэд чиглэсэн орон нутгийн чадавхийг дээшлүүлэв.....	15
Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулахад анхаарав.....	15
Нийгмийн даатгалын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэв.....	16
Дүгнэлт, зөвлөмж.....	19
Дүгнэлт.....	19
Зөвлөмж.....	21
Хавсралт 1. Хөдөлмөрийн яамнаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй зарим хөтөлбөрийн мэдээлэл.....	25
Хавсралт 2. Туршилтын хөтөлбөрийн үйл ажиллагааны хуанли.....	27

ОУХБ/Япон Улсын Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжүүлсэн “Монгол Улсад нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих, АСЕАН-ы туршлагаас суралцах нь” буюу МАПС төсөл нь Монгол Улсад нийгмийн хамгааллыг өргөжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой. Тус төслийн хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг нь хөдөө орон нутгийн залуучуудын орлогын баталгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ахмад настан(малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус салбарт ажиллагчид)-ы орлогын баталгааг хангах арга хэмжээг төлөвлөх, эдгээр үйлчилгээг хүргэх механизмыг сайжруулахад Засгийн газар, нийгмийн түншүүдэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн юм.

Энэхүү тайланд Баянхонгор, Өвөрхангай аймгийн тус бүр нэг суманд залуу малчдын хөдөлмөр эрхлэлт, орлогын баталгааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн туршилтын хөтөлбөрийн стратеги, үр дүнг танилцуулав. Туршилтын хөтөлбөр нь бүтээмжтэй хөдөлмөр эрхэлж орлогын баталгаагаа бүрдүүлэхэд малчдад тулгардаг бэрхшээлийг цогцоор шийдвэрлэх боломжид анхаарал хандуулсан байна.

Уг туршилтын хөтөлбөр сонгогдсон хоёр сум(Галуут, Нарийнтээл)-нд 2015 оны 7 дугаар сараас 2016 оны 5 дугаар сар хүртэл хэрэгжиж (хөтөлбөрийн төлөвлөлтийг 2014 оны 6 дугаар сараас эхэлсэн), 6 хоршооны гишүүн 35-аас доош насны 90 залуу малчин өрхийг хамруулжээ.

Туршилтын хөтөлбөрийн стратегийг зорилтот сумдын нийгэм, эдийн засгийн байдлын үнэлгээ, орон нутгийн холбогдох талуудын уулзалт хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан боловсруулжээ. Хөтөлбөрийн стратеги нь малчдад бизнес эрхлэх сургалт, бизнесийн зөвлөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, ур чадварыг нь хөгжүүлэх, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх; хоршоог хөгжүүлэх; хөдөлмөр эрхлэлтийн алба болон нийгмийн даатгалын ажилтнуудын чадавх бэхжүүлэх зэрэгт чиглэгдэв. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд сургалтын материал боловсруулах, сургагч багшийг бэлтгэх, төслийн үр шим хүртэгчдийг сургахаас гадна тэдний орлогын эх үүсвэрт зориулж орон нутгийн засаг захиргаанаас тоног төхөөрөмж, зээлийн дэмжлэг үзүүлэх ажлыг голлон зохион байгуулжээ. Төрийн албан хаагчдын сургалт нь төрийн холбогдох үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд эдгээрийн нийт 482 хүн хамрагдсанаас 62 хувь нь эмэгтэйчүүд байв.

Энэхүү тайланд туршилтын хөтөлбөрийн дараах гол үр дүн, сургамжийг танилцуулав:

- 1. Сонгогдсон сумдын малчид, бусад иргэдэд зориулсан бизнесийн зөвлөх үйлчилгээ нэвтрүүлэв.** Туршилтын хөтөлбөрийн хүрээнд ОУХБ-ын “Бизнесээ эхэл, хөгжүүл” хөтөлбөрийн аргачлалаар сургагч багш бэлтгэх, малчид бизнесийн анхан шатны ойлголтыг бие даан суралцахад зориулсан гарын авлага боловсруулах замаар бизнес эрхлэх сургалтыг сумын түвшинд зохион байгуулах чадавхийг бэхжүүлжээ. Үр дүнд нь зорилтот хоёр суманд бизнесийн зөвлөх үйлчилгээ (Бизнес эрхлэх сургалт, зөвлөх нэгж) бий болжээ. Ийнхүү малчид болон сумын бусад иргэд МАПС төсөл дууссанаас хойш ч мөн бизнес эрхлэх сургалтад хамрагдах, жижиг бизнесийн талаар зөвлөгөө авах боломжтой болсон байна.
- 2. Залуу малчдын бүтээмжтэй хөдөлмөр эрхэлж амьжиргаагаа дээшлүүлэх ур чадварыг хөгжүүлэв.** Сум бүрт залуу малчид, хоршооны гишүүдэд зориулж сүү, ноос, арьс шир, мах боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх сургалт зохион байгуулжээ. Залуу малчид түүхий эд боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинэ ур чадвар эзэмшсэнээр орлогын нэмэлт эх үүсвэртэй болох сонирхол, итгэл нь нэмэгдэж байна. Сургалтаар хөдөө орон нутагт мартагдах шахсан зарим уламжлалт арга ажиллагааг сэргээхэд нөлөө үзүүлэв. Мөн орон нутгийн удирдлагууд

залуу малчдын бизнес санаачилгыг бодитой дэмжиж “Сум хөгжүүлэх сан”-аас хөнгөлөлттэй зээл олгох, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-өөс малжуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр дэмжлэг үзүүлжээ. Залуу малчид амьжиргаанд нь нэмэр болох, тэдний хэрэгцээнд нийцсэн, чанартай сургалтад хамрагдах сонирхолтой байдаг болохыг туршилтын төсөл харуулжээ.

3. **Бие даан суралцах замаар залуу малчдын идэвх өрнөв.** Залуу малчдад уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхлэх арга ухаан төдийгүй мал маллагааны орчин цагийн шаардлагын талаар мэдлэг, мэдээлэл олгоход туршилтын хөтөлбөр анхаарал хандуулжээ. Малчид энэ бүгдийг бие даан суралцах шинэлэг аргачлалыг нэвтрүүлсэн нь туршилтын хөтөлбөрийн онцлог юм. ОУХБ-ын өмнөх төслийн хүрээнд боловсруулсан “XXI зууны малчин” багц модулийг залуу малчид орон нутгийн төрийн албан хаагчид, хоршооны гишүүдийн дэмжлэгтэйгээр судалсан байна. Бие даан суралцах арга барил үр дүн авчрах боломжтой нь харагдсан бөгөөд уг гарын авлагыг ахмад, залуу гэлтгүй малчид мэддэг, сурагладаг болжээ. Иймд төслийн зөвлөмжийг үндэслэн Хөдөлмөрийн яамнаас уг багцыг хөтөлбөрт хамрагдсан хоёр аймгийн нийт сумдад тарааж туршихаар шийдсэн байна. Ийнхүү туршилтын хөтөлбөр нь Засгийн газрын “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болжээ.
4. **Ирээдүйгээ харахуй: Малчдын хөдөлмөр эрхлэлт, амьжиргааг дээшлүүлэхэд хоршооны гүйцэтгэх үүрэг.** Туршилтын хөтөлбөрийн олон үйл ажиллагаа хоршоог дэмжих, түүний үнэ цэнийг өсгөхөд анхаарал хандуулжээ. Хоршооны дарга, гишүүдэд гэрээ хэлцэл хийх, маркетинг, харилцаа, менежментийн ур чадвар олгох сургалтын цогц хөтөлбөр шаардлагатай байгааг тодорхойлсны үндсэн дээр ОУХБ-ын “Манай хоршоо - Хөдөө аж ахуйн хоршоог удирдах нь” сургалтыг Монголын малчдын хоршооны онцлогт нийцүүлэн зохион байгуулсан юм. Уг сургалт нь хөдөө аж ахуйн хоршооны хөгжлийг дэмжих сургалтын багц хөтөлбөрийг анх удаа нэвтрүүлснээрээ ихээхэн ач холбогдолтой болжээ.
5. **Хөдөө орон нутгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг сайжруулж, орлогын баталгааг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн албан хаагчдыг чадавхжуулав.** Туршилтын хөтөлбөрийн хүрээнд хоёр аймгийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний болон нийгмийн даатгалын ажилтнуудад чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулжээ. Төслийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудад зориулсан сургалтын ерөнхий хөтөлбөр боловсруулахад нь Хөдөлмөрийн яаманд дэмжлэг үзүүлэхэд чиглэгджээ. Цаг хугацааны давчуу байдлын улмаас энэхүү үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж чадаагүй ч ОУХБ-аас Хөдөлмөрийн яаманд сургалтын материал боловсруулахад нь ойрын үед дэмжлэг үзүүлэх болно. Нийгмийн даатгалын ажилтнуудад зориулсан чадавх бэхжүүлэх сургалт нь тэдний хандлага, арга ажиллагаа, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах замаар эмзэг бүлгийнхний сайн дурын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэгджээ. Мөн малчдад зориулж нийгмийн даатгалын талаар бие даан суралцах гарын авлага боловсруулсан байна. Туршилтын хөтөлбөрийн хоёр сумын малчдын мэдлэг мэдээллийг дээшлүүлэхэд нийгмийн даатгалын ажилтнуудын оролцоо сайжирч, үр шим хүртэгчдийн сайн дурын нийгмийн даатгалд хамрагдалт мэдэгдэхүйц нэмэгджээ.

Туршилтын хөтөлбөрийн туршлагаас дараах хэдэн сургамжийг олж авлаа:

- Малчдын мэдлэгийг зузаатгаж, бие даан суралцах үйлийг дэмжихэд мал эмнэлэг, үржлийн асуудал хариуцсан ажилтнуудыг оролцуулах нь нэн чухал.
- Хоршооны менежментийг сайжруулах үйл ажиллагааг хоршооны бизнес, гишүүдийнх нь ур чадварыг хөгжүүлэх ажилтай нягт уялдуулахын тулд хоршоог дэмжих үйл ажиллагааг төслийн эхэн үед төлөвлөх хэрэгтэй байв.

- Малчдын ур чадварыг хөгжүүлэх сургалтыг тогтвортой, өргөн хүрээнд зохион байгуулахад аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо чухал үүрэгтэйг орхигдуулсан байна. Иймд цаашдын хөтөлбөрүүдэд малчдын хоршоо болон аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны уялдаа холбоог бэхжүүлэх асуудлыг авч үзэх хэрэгтэй.
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулахад туршилтын хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагаа хангалтгүй, тиймээс энэ чиглэлээр цогц үйл ажиллагаа шаардлагатай.
- Нийгмийн даатгалын ажилтнуудын хандлага, арга барилыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэх, ялангуяа малчдын хоршооны тухай зөв ойлголттой болж, малчдын хоршоодтой түншлэлийн зарчмаар зохистой хамтран ажиллахыг дэмжих шаардлагатай.

Туршилтын хөтөлбөрийн үр нөлөөг түгээн дэлгэрүүлэх зорилгоор дараах зөвлөмжийг Засгийн газар, нийгмийн түншүүд, орон нутгийн удирдлага, хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо, малчдын хоршоодод хүргэж байна:

Залуу малчдын ур чадварыг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх

- “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд залуу малчдын ур чадварыг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд анхаарах
- Туршилтын хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан сургалтын дөрвөн гарын авлагыг малчдын ур чадварыг хөгжүүлэх, амьжиргааг дээшлүүлэх зорилгоор өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэх

Сумын түвшинд бизнес эрхлэх сургалт, бизнесийн зөвлөх үйлчилгээг бий болгох

- Бизнес эрхлэх сургалт, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чадавх бүрдүүлэх
- Тус хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан гарын авлагуудыг хуулбарлах, ашиглахтай холбогдсон зааварчилгаа гарган чанарын баталгааг хангах, тэдгээрийг хэрэглэхийг сонирхсон бусад байгууллагад дэмжлэг үзүүлэх

Хөдөө аж ахуйн хоршооллын хөгжлийг дэмжих

- Гишүүддээ үйлчлэх, хоршооны бизнесээ хөгжүүлэх чадавхийг нь бэхжүүлэх зорилгоор малчдын хоршоодод зорилтот дэмжлэг үзүүлэх
- Малчдын хоршооны хөгжлийн эхэн үе шатанд хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай байдагт анхаарал хандуулах
- Засгийн газар болон Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооноос малчдын хоршоог хөгжүүлэх талаар баримтлах бодлого, стратегия далайцтай болгох

Малчдын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх

- Малчид сайн дурын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд даатгуулах, шимтгэл төлөх ажиллагааг хөнгөвчлөх
- Малчдын шимтгэл төлөлтийг илүү уян хатан зохион байгуулах

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудыг чадавхжуулах, орон нутгийн холбогдох талуудын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтыг сайжруулах

- Үйл ажиллагааны дэс дараалал, дүрэм журам, сургалтын материал боловсруулах, боловсон хүчнийг чадавхжуулах цогц арга хэмжээ хэрэгжүүлж хөдөлмөр

эрхлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх

- Төрийн бодлого, хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэхийн тулд яамдын харъяа сумын түвшний албан хаагчдын чиг үүрэг, үйл ажиллагааг үр дүнд чиглэсэн, түншлэлд суурилсан зарчмаар уялдуулан зохицуулах
- Аймаг, үндэсний түвшний төрийн байгууллагуудын үүрэгт ажлын уялдаа, зохицуулалт болон төр, төрийн бус байгууллага, холбоо, сургалт, судалгааны байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг хангах замаар төрийн бодлого, үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулах

МАПС төслийн туршилтын хөтөлбөрт хамрагдсан орон нутгийн холбогдох талууд, малчдын хоршоодод өгөх зөвлөмж

- Сумын түвшинд бий болсон бизнесийн зөвлөх үйлчилгээг тогтвортой үргэлжлүүлж, улам бэхжүүлэх
- Залуу малчдын бие даасан сургалтын үр дүнд тавих хяналтаа үргэлжлүүлж, шаардлагатай дэмжлэг үзүүлэх
- Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх сургалтад хамрагдах залуу малчид, хоршооны гишүүдийн тоог нэмэгдүүлэх
- Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын ач холбогдлын талаар малчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх
- Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоотой хамтран малчдын хоршооны хөгжилд дэмжлэг үзүүлэх
- Төсөлд хамрагдсан хоршоодын алсын хараа, стратегийг тодорхойлох, хоршооны гишүүдэд зориулсан үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хоршооны гишүүдийн харилцан итгэлцэл, эв нэгдлийг бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлэх.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АСЕАН	Зүүн өмнөд Азийн орнуудын нийгэмлэг
БЭХ	“Бизнесээ эхэл, хөгжүүл” хөтөлбөр
МАПС	ОУХБ/Япон Улсын Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжүүлсэн “Монгол Улсад нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих, АСЕАН-ы туршлагаас суралцах нь төсөл”
МХААХҮХ	Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо
МХСМТ	Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төв
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Олон улсын хөдөлмөрийн байгууллага/Япон Улсын Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжүүлсэн “Монгол Улсад нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих, АСЕАН-ы туршлагаас суралцах нь”¹ буюу МАПС төсөл нь тус улсад нийгмийн хамгааллыг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ялангуяа өндөр настан, хөдөлмөрийн насны иргэдийн орлогын баталгааг хангахад чиглэгдсэн. Тус төслийг Япон Улсын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яам, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо хамтран хэрэгжүүлсэн юм.

Энэхүү төсөл нь бүс нутгийн болон Монгол Улсын түвшинд хэрэгжсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй. Эхний бүрэлдэхүүн хэсэг нь Зүүн өмнөд Азийн орнуудын нийгэмлэг буюу АСЕАН-ы гишүүн орнуудын Засгийн газар, нийгмийн түншүүдийг эмзэг бүлгийн орлогын баталгааг хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр чадавхжуулах зорилготой. Хоёр дахь бүрэлдэхүүн хэсэг нь Монгол Улсын Засгийн газар, нийгмийн түншүүдийг хөдөө орон нутгийн залуучуудын орлогын баталгааг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчдын орлогын баталгааг хангах арга хэмжээг төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх зорилготой. Түүнчлэн энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд орлогын баталгааг хангах, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх механизмыг боловсронгуй болгоход анхаарал хандуулжээ.

Монгол Улс нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн хөтөлбөрүүдээс бүрддэг

¹ Төслийн бүсийн түвшинд хэрэгжсэн бүрэлдэхүүн хэсгийг хамруулсан дэлгэрэнгүй нэр нь: “ОУХБ/Япон Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн Азийн улс орнуудад орлогын баталгаа, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих төслийн 2 дахь үе шат: АСЕАН-ы туршлагыг харгалзан Монгол Улсад хэрэгжүүлэх нь”

өргөн хүрээ бүхий нийгмийн хамгааллын тогтолцоотой. 1990-ээд оны сүүл үеэс хэрэгжүүлж эхэлсэн хөдөлмөрийн зах зээлийн бодлого нь эмзэг бүлгийнхний ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөрийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсээр ирсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр олон хөтөлбөр хэрэгжүүлсэн ч малчдыг шаардлагатай хэмжээнд хамруулж чадахгүй байна. Малчдын нийгмийн даатгалд хамрагдалт ч мөн бага байна.

Малчдын амьжиргаанд цаг уурын хүнд нөхцөл, бэлчээрийн цөлжилт, талхлагдалт, бэлчээр ашиглах арга ухааны доголдол нөлөөлдөг. Түүнчлэн боловсруулсан түүхий эдийг зах зээлд борлуулах тухай малчдын мэдлэг, чадвар дутмаг, энэ чиглэлээр тусалж дэмжих механизм хомс байдгаас гадна мэдээлэл, хөрөнгийн эх үүсвэр сайтай ченжүүдийн сүлжээний улмаас малчид түүхий эдээ зохих үнээр нь борлуулж чаддаггүй. Ялангуяа зах зээлийн эдийн засагт шилжих эхэн үед хөдөө аж ахуйн хоршоодыг татан буулгасны дараа малчдын нийтлэг ашиг сонирхол, тулгамдсан асуудлуудаа хамтран шийдвэрлэх, улмаар эдийн засаг, нийгмийн хөгжлөө хангахад нь туслах хөдөөгийн институцийн хөгжил сул байсаар ирэв. Эдгээр хүчин зүйлс нь малчдын эдийн засгийн цочир хүндрэл, байгаль цаг уурын гамшигт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж, улмаар хөдөөд ядуурал их байх нэг шалтгаан болж байна. Ядуурлын түвшин 2014 оны байдлаар хот суурин газарт 18.8 хувь, хөдөө орон нутагт 26.4 хувь байв.²

Дээрх нөхцөл байдлын үүднээс авч үзвэл залуу малчин өрх илүү эрсдэлтэй амьдардаг. Тэдний олонх нь хангалттай орлого олоход хүрэлцэхээргүй цөөн малтай. Цаг уурын хүнд нөхцөл, гэнэтийн сорилт бэрхшээл, эрсдэлийг даван туулах туршлага, малч арга ухаанаар олон залуу малчид дутагдаж байна.

Иймд ОУХБ/Япон Улсын Засгийн газраас хамтран хэрэгжүүлсэн МАПС төслийн хөдөө орон нутгийн залуучуудад чиглэсэн туршилтын хөтөлбөр нь бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, орлогын тогтвортой эх үүсвэртэй болоход малчдад тулгардаг сорилтыг шийдвэрлэх цогц аргачлал ашиглажээ. Тус хөтөлбөр нь нийгмийн хамгаалал, бизнес эрхлэх ухаан, ур чадвар хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлыг малчдын хоршоог дэмжих үйл ажиллагаатай хослуулах замаар төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөөг сайжруулах зорилт тавьсан байна.

Туршилтын үйл ажиллагааг Баянхонгор аймгийн Галуут, Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд хэрэгжүүлж, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т заасан зорилтот бүлгийг, тухайлбал, эхнэр, нөхөр хоёул 35 хүртэлх насны малчин өрхийг хамруулсан байна. Сум бүрт 3 хоршоо, хоршоо тус бүрээс 15 залуу малчин өрх буюу дээрх хоёр суманд нийтдээ 90 өрх (90 эрэгтэй, 90 эмэгтэй малчин) туршилтын хөтөлбөрт хамрагджээ.

Хөтөлбөрийн стратегийг нарийвчлан боловсруулах ажил 2014 оны 6 дугаар сараас эхэлж, үйл ажиллагаа нь 2015 оны 7 дугаар сараас 2016 оны 5 дугаар сард хэрэгжсэн байна. Туршилтын хөтөлбөр хэдийгээр богино хугацаанд хэрэгжсэн ч гэлээ энэхүү тайланд дурьдсанчлан чамлахааргүй үр дүнд хүрчээ.

Энэхүү тайланд туршилтын хөтөлбөрийн амжилт бүтээлийг дурьдсанаас гадна олж авсан сургамж, Монгол Улсын хөдөө орон нутгийн залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломж, орлогын баталгааг сайжруулахын тулд Засгийн газар, нийгмийн түншүүдийн анхаарвал зохих бодлогын зөвлөмжийг тусгалаа.

² Эх сурвалж: www.worldbank.org/en/news/press-release/2015/07/01/poverty-continued-to-decline-falling-from-274-percent-in-2012-to-216-percent-in-2014 (2016 оны 7 дугаар сарын 1-нд авав).

Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд

Туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд сайжруулах боломжтой асуудлуудыг тодорхойлжээ. Тиймээс хөдөөгийн залуучуудын ур чадварыг хөгжүүлэх, амьжиргааг дэмжих асуудалтай шууд болон тодорхой хэмжээнд холбоотой Засгийн газрын зарим хөтөлбөр, үйл ажиллагааг доор товч танилцуулав.

Засгийн газрын хөдөлмөрийн зах зээлийн бодлого нь ажил хайгчдад зориулсан зөвлөгөө өгөх, ажилд зуучлах үйлчилгээ, түүнчлэн ажилгүйчүүд, ажилгүйдэлд өртөж болзошгүй буюу жижиг бизнесээ алдах эрсдэлтэй хүмүүс, ажил олоход хүндрэлтэй иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 35 хүртэлх насны амьжиргааны түвшин доогуур малчид, бичил бизнес эрхлэгч, хоршоо, нөхөрлөл байгуулах иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, их дээд, сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгсөгчид зэрэг олон зорилтот бүлэгт чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдээр дамжиж хэрэгждэг.

Хөдөлмөрийн хэлтсүүд нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн дагуу хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөрүүдийг улс орон даяар хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд ажил хайж буй иргэд болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэх (үйлдвэрлэл дээрх болон мэргэжлийн сургалт), хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус салбарт ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, баталгааг дээшлүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр болон нийтийг хамарсан ажил зэрэг арга хэмжээ багтдаг. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр” зэрэг нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, их, дээд сургууль төгсөгчид, дунд сургуулийн сурагчид, ажил олоход хүндрэлтэй иргэдэд чиглэдэг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дээрх хөтөлбөрүүдээс гурав нь малчдын ур чадварыг хөгжүүлэх, амьжиргааг сайжруулах үйл ажиллагаатай шууд холбоотой буюу холбогдох боломжтой. Үүнд: “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр” (Хавсралт 1-ээс эдгээр хөтөлбөртэй дэлгэрэнгүй танилцана уу).

Эдгээрээс гадна малчдад хөнгөлөлттэй зээл олгодог “Сум хөгжүүлэх сан” нь төрөөс хэрэгжүүлж буй чухал арга хэмжээ юм. Орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор Засгийн газрын тогтоолын дагуу байгуулсан энэхүү эргэлтийн сангийн хөрөнгийг Сангийн яамнаас хуваарилдаг бөгөөд зарцуулалт зохион байгуулалтыг орон нутаг хариуцдаг. Тус сангаас жилийн 3 хувийн хүүтэй зээлийг 3 хүртэл жилийн хугацаагаар авч болно. Сангийн журамд саяхан өөрчлөлт³ орж тухайн жилд олсон хүүгийн орлогын 30 хүртэл хувийг зээл авч буй хүмүүст зориулсан сургалтад зарцуулах эрхийг орон нутгийн удирдлагад олгосон байна.

Мөн Засгийн газар “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-г байгуулж, 5 хүртэл жилийн хугацаатай, жилийн 9 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл (эхний жилд зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөнө), санхүүгийн түрээс буюу лизингийг арилжааны банкаар дамжуулж олгож байна. Тус сангаас олгох зээлийн хэмжээ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болон “Сум хөгжүүлэх сан”-гийнхтай харьцуулахад их байна.

2016 оны эхээр Засгийн газраас малчдад чиглэсэн хоёр хөтөлбөр баталсан юм. Үүнд:

3 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдөр баталсан.

“Сайн малчин хөтөлбөр”,⁴ “Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр”.⁵ Эдгээр хөтөлбөрийн үр дүнд Төрийн банкнаас малчдад олгодог зээлийн жилийн хүүг 29.5 хувиас (нийт малчдад) 18 хувь, (нийгмийн даатгалд хамрагдалт зэрэг тодорхой шалгуур хангасан малчдад) 10 хувь болгон бууруулжээ.

Туршилтын хөтөлбөрийн стратеги, үйл ажиллагаа

Гишүүдийнхээ эдийн засаг, нийгмийн сайн сайхны төлөө малчдын хоршооны гүйцэтгэх үүргийг онцлохын сацуу ур чадвар хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээний уялдааг оновчтой болгохын тулд хөдөө орон нутгийн залуучуудад чиглэсэн туршилтын хөтөлбөрийн хүрээнд дараах үндсэн 6 стратегийг баримталжээ. Үүнд:

1. Бизнес хөгжүүлэх үйлчилгээг сумын түвшинд бий болгох
2. Малчдын бизнесийн ур чадварыг хөгжүүлэх, нэмүү өртгийн сүлжээнд нэгдэхэд нь дэмжлэг үзүүлэх
3. Мал аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх, орлогын эх үүсвэрийг олшруулах, малын гаралтай бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх талаар залуу малчид болон хоршооны бусад гишүүдийн ур чадварыг сайжруулах
4. Мал аж ахуй эрхлэх, малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах талаар залуу малчдад зориулсан сургалтын хөтөлбөр, бие даан суралцах гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах
5. Сонгогдсон хоршоодын гишүүддээ үйлчлэх менежментийн чадавхийг бэхжүүлэх
6. Залуу малчдын нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх, малчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын үйлчилгээний чадавхийг дээшлүүлэх, малчдын хоршоодтой хамтран ажиллах түншлэлийг хөгжүүлэх.

Туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор аймгийн түвшинд байгуулсан “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн ажлын хэсэг”-ээс зорилтот сумдад хийсэн нийгэм, эдийн засгийн байдлын үнэлгээнд тулгуурлан төслийн баг, олон улсын зөвлөхүүдтэй зөвшилцөх замаар дээрх стратегийг тодорхойлжээ. Хөдөлмөр эрхлэлтийн болон нийгмийн даатгалын ажилтнуудыг чадавхжуулах зэрэг дунд түвшний стратегийг туршилтын хөтөлбөрт анхнаасаа тусгажээ.

Хөтөлбөрийн стратегийг боловсруулахад орон нутгийн түншүүдийг өргөн хүрээнд татан оролцуулснаараа давуу талтай болсон байна. Гэсэн хэдий ч ОУХБ-ын “Хөдөөгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх сургалт”-ын арга зүйг баримталсан төлөвлөлтийн үе шат хэт их цаг авч үйл ажиллагааны хэрэгжилтэнд нэг жилээс бага хугацаа үлдсэн байна.

⁴ Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 113 дугаар тогтоолоор баталсан.

⁵ Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор баталсан.



Хөдөөгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх сургалт нь ОУХБ-ын зүгээс 1990-ээд оны эхээр хөдөө орон нутагт зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөр юм. Уг хөтөлбөр нь ядуу, албан бус салбарт ажиллагчид, бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, ажилгүйчүүд болон бусад төрлийн бэрхшээлтэй иргэдэд эдийн засгийн болон хөдөлмөр эрхлэлтийн шинэ боломж бий болгохын тулд тэдэнд мэдлэг, ур чадвар эзэмшүүлэхийг чухалчлан анхаардаг. Тус хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах замаар орлого бий болгох үйл ажиллагаа, орон нутгийн хөгжлийг дэмждэг.

Энэ нь орон нутагт анхан шатанд хэрэгжүүлэх аргачлал бүхий хөтөлбөр учраас алслагдмал хөдөө нутгийн иргэдийг орлогоо нэмэгдүүлэх чадавхитай болгох сургалтыг илүү үр дүнтэй зохион байгуулах; орон нутгийн эдийн засгийн хөгжлийн үйл явцыг удирдан чиглүүлэхэд нь орон нутгийн бүлгэмүүдийн ахлагч, гишүүдэд туслах; орон нутгийн хөгжлийн үйл ажиллагаанд сургалтын бусад арга хэрэгсэл, арга зүйг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

Эх сурвалж: www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_159165.pdf,
(2016 оны 7 дугаар сарын 1-нд авав).


Туршилтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалтад нийт 482 хүн хамрагдсанаас 62 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хавсралт 2-т туршилтын хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжсэн цаг хугацааны дарааллын дагуу дэлгэрэнгүй тусгав. Дараагий хуудсанд буй бүдүүвчээр хөтөлбөрийн үйл ажиллагааг (орон нутгийн удирдлагуудтай хамтарч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг оролцуулан) гарсан үр дүнтэй нь холбож харууллаа. Хөтөлбөрт хамрагдсан хоёр сумын удирдлага хөтөлбөрийн үр шим хүртэгч-хоршооны гишүүдийн бизнес санаанд мөнгөн бус дэмжлэг үзүүлэх, бичил зээл олгох, шалгуурт тэнцсэн өрхүүдийг Хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж буй “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамруулах зэргээр олон талаар дэмжсэн байна. Бичил зээлийг “Сум хөгжүүлэх сан” болон Хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж буй “Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон ажээ.

Туршилтын хөтөлбөрт хамрагдсан хоршоод гишүүдийнхээ бизнес санаачилгыг дэмжихдээ илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх болжээ. Орон нутгийн удирдлага болон хоршоодын зүгээс залуу малчдад үзүүлсэн эдгээр дэмжлэг нь хөтөлбөрийн үр дүнд эерэгээр нөлөөлсөн байна.

Ихэнх үр шим хүртэгч болон орон нутгийн холбогдох талууд хөтөлбөрийн үйл ажиллагааг тэдний амьдрал ахуйд нийцсэн, шинэлэг болсон гэж дүгнээд, туршилтын хөтөлбөр нь цаашид малчид, орон нутгийнхан хоршооны хөгжил, ур чадварыг сайжруулах чиглэлээр ажиллах эх суурийг тавьж өгсөн гэж онцолж байлаа.

ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ГОЛ ҮР ДҮН

Энэхүү бүлэгт туршилтын хөтөлбөрийн хүрээнд бий болсон биет болон биет бус үр дүн, сургамжуудыг онцлон танилцуулав. Хэрэв хөтөлбөрт хамрагдсан малчдын хоршоод, орон нутгийн холбогдох талууд үргэлжлүүлэн хамтран ажиллаж, хүрсэн үр дүнгээ цаашид хадгалж, өргөжүүлбэл олон хүнд өгөөжөө өгөх, амьжиргаанд нь хувь нэмэр болох боломжтой юм.

Малчид, орон нутгийн иргэдэд бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ бий болов

Малчдад аж ахуй эрхлэх арга ухааны мэдлэг, мэдээлэл хэрэгтэй байдаг ч тийм үйлчилгээг сумынхаа түвшинд авч заншаагүй юм. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд бизнесийн зөвлөх үйлчилгээг зорилтот сумдад нэвтрүүлсэн нь малчдын хувьд үнэхээр шинэлэг зүйл болжээ. Хөтөлбөрт хамрагдсан хоёр суманд бизнесийн зөвлөх үйлчилгээ (Бизнес эрхлэх сургалт, зөвлөгөө өгөх нэгж) бий болгожээ. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сум уг үйлчилгээг Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төвийн үйл ажиллагааны хүрээнд байгуулсан бол Баянхонгор аймгийн Галуут сум Нэг цонхны үйлчилгээний хүрээнд багтаасан байна. Үүний үр дүнд сумын малчид, иргэд аж ахуй эрхлэх сургалт, жижиг бизнес хөгжүүлэх зөвлөгөөг амар хялбар авах боломжтой болжээ.



Туршилтын хөтөлбөр нь бизнес хөгжүүлэх дэмжлэгийг багц хэлбэрээр хэрэгжүүлжээ. Эхлээд сум бүрт ОУХБ-ын БЭХ хөтөлбөрийн сургагч багш нарын багийг бэлтгэсэн байна. Тус багийг нь орон нутгийн төрийн албан хаагчид (жижиг, дунд үйлдвэр хариуцсан ажилтан, албан бус боловсролын арга зүйч гэх мэт) болон хоршоодын дарга нараас бүрдүүлжээ. Бэлтгэгдсэн сургагч багш нар залуу малчид болон зээлд хамрагдахаар өргөдөл гаргасан, жижиг, дунд бизнес эрхлэгч зэрэг сумын бусад сонирхсон иргэдэд бизнес эрхлэх сургалт зохион байгуулжээ. Малчдад зориулсан сургалтын хэлбэр хоёр сумын хувьд ялимгүй ялгаатай байлаа. Галуут суманд сургалтыг сумын төвд зохион байгуулсан бол Нарийнтээл суманд малчны хотонд ойр буюу багийн төвд явуулсан байна. Сургалтыг малчдын хувьд оролцох хамгийн боломжтой үе буюу зуны улиралд зохион байгуулжээ.



“Бизнесээ эхэл, хөгжүүл (БЭХ)” сургалт нь ОУХБ-аас боловсруулсан менежментийн сургалтын хөтөлбөр бөгөөд хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудад ажлын байр нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг сайжруулах зорилгоор жижиг бизнес эхлүүлэх, хөгжүүлэхэд анхаарлаа хандуулдаг хөтөлбөр юм. БЭХ сургалт нь дараах зорилтыг дэвшүүлдэг. Үүнд: (i) орон нутагт бизнесийн хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг бизнесийн гарааны болон хөгжлийн сургалт, холбогдох бусад үйл ажиллагааг үр дүнтэй, бие даан зохион байгуулах чадавхтай болгох; (ii) жижиг бизнес эрхлэх чадвартай болон жижиг бизнес эрхэлж буй эрэгтэй, эмэгтэйчүүдийг амьдрах чадвартай бизнес эхлүүлэх, өргөжүүлэх, бусад хүмүүст зориулан чанартай ажлын байр бий болгоход нь дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

Эх сурвалж: www.ilo.org/empent/areas/start-and-improve-your-business/lang-en/index.htm
(2016 оны 6 дугаар сарын 30-нд авав.)

ОУХБ-аас боловсруулсан **“Орон нутагт аж ахуй хөгжүүлэх”** сургалтын хөтөлбөр нь өртөг багатай, хэрэгжүүлэхэд хялбар аргачлалтай бөгөөд ялангуяа хөрөнгийн дэмжлэг хязгаарлагдмал ядуу, эмзэг, алслагдмал, бөглүү нутагт бизнес эхлүүлэхийг зорьсон хүмүүст туслах, бичил бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг сайжруулах зорилготой. Энэ нь бизнесийн гараа, явцыг хэрхэн зохион байгуулахаас авахуулаад санхүүгийн мэдлэг, жижиг фермийн аж ахуйн менежмент, санхүүгийн эх үүсвэр олох зэрэг олон сэдвийг хамарсан сургалтын хөтөлбөр юм.

Эх сурвалж: www.ilo.org/asia/whatwedo/projects/WCMS_375173/lang-en/index.htm
(2016 оны 6 дугаар сарын 30-нд авав.)



Залуу малчдын бизнес эрхлэх ур чадварыг дээшлүүлэх зорилгоор боловсруулсан бие даан суралцах гарын авлага нь багц үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг юм. Хөтөлбөрийн эхэнд хийсэн нийгэм, эдийн засгийн үнэлгээгээр малчид бизнес эрхлэх сургалтад хамрагдаж чаддаггүй, сургалтын зохих гарын авлага, материал олддоггүй болохыг тодорхойлсон байна.

Монгол малчдын онцлогт тохирсон бие даан суралцах гарын авлагыг БЭХ болон “Орон нутагт аж ахуй хөгжүүлэх” сургалтын материалуудыг ашиглан боловсруулсан ажээ. Түүнчлэн бие даан суралцах гарын авлагыг хэрхэн ашиглах талаар БЭХ хөтөлбөрийн сургагч багш нар малчдад зөвлөгөө өгч ажилласан байна.

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Засаг дарга **Түмэнжаргал**: “ОУХБ-ын төслөөс сумын түвшинд бизнес эрхлэх чиглэлээр сургагч багш нарын баг бий болгосон нь түүхэнд байгаагүй ололт амжилт юм. Ур чадвар хөгжүүлэх сургалтыг малчдад ойртуулсан нь амжилттай болсон.” (хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээний үеэр авсан ярилцлагаас, 2016 оны 10 дугаар сар)

Бизнес эрхлэх сургалт болон бие даан суралцах үйлийг дэмжсэн нь зарим малчдын хувьд бизнесийн талаарх ойлголтоо дээшлүүлэх, бизнесийн санаа олох, зээл авахад шаардагдах бизнесийн төсөл боловсруулах чадавхийг нь дэмжихэд шууд нааштайгаар нөлөөлжээ. Тухайлбал, сургалтын үр шим хүртэгчдийн нэлээд хэд нь бизнесийн төсөл боловсруулж, сумын удирдлагад хандан зээл хүсээд байна. Тэдний зарим нь “Сум хөгжүүлэх сан”-гаас хөнгөлөлттэй зээл авчээ. Нутгийн удирдлагуудын хэлж байгаагаар хоёр сумын иргэдийн боловсруулсан бизнесийн төслийн чанар үлэмж сайжирсан ажээ.

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын “Мандухайн шивээ” хоршооны малчин **Ууганбаяр** БЭХ сургалтад хамрагдсанахаа дараа өвөлжөө барих зорилгоор 2 сая төгрөгийн зээл хүссэн төсөл бичиж, “Сум хөгжүүлэх сан”-д ханджээ. Тэрээр зээлээ авахын сацуу “ХХI зууны малчин” бие даан суралцах гарын авлагыг уншиж судлаад олж авсан мэдлэгээ ашиглан өвөлжөөгөө барьсан байна.

2016 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар бизнес эрхлэх, ур чадварын сургалтад хамрагдсан зорилтот 6 хоршооны гишүүдээс 42 хүн (үүнээс 25 хувь нь эмэгтэйчүүд) бизнес төлөвлөгөөгөө боловсруулжээ. Зээл авахаар хүсэлт гаргасан эдгээр хүмүүсийн 31 (үүнээс 7 нь эмэгтэй) нь хөнгөлөлттэй зээл авснаас гадна ахиад 8 төслийг “Сум хөгжүүлэх сан”-гийн хөрөнгийн боломж бүрдвэл авч үзэхээр хүлээгдэж байгаа ажээ.

Хөтөлбөрт хамрагдсан нийт (90) залуу малчин өрхийн 28 хувь (25 өрх) нь хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт гаргаснаас 88 хувь (22 өрх) нь зээл авчадсан байна. Харьцангуй цөөн эмэгтэйчүүд зээл авах хүсэлт гаргасныг өрөөсгөлөөр тайлбарлаж болохгүй юм. Учир нь өрхийн тэргүүн зээлийн хүсэлт гаргадаг ч зээлийн гэрээнд эхнэр, нөхөр хоёул гарын үсэг зурж баталгаажуулдаг жишиг нийтлэг байна. Түүнчлэн Монголын хот, хөдөө ялгаагүй нийт айл өрхийн хувьд эмэгтэйчүүд (эхнэр) гэрийнхээ санхүүгийн гол менежер нь байдаг бөгөөд Монгол эмэгтэйчүүд (эхнэр) хөрөнгө, мал зарах, худалдаж авах гэх мэт гэр бүлийн чухал асуудлаар шийдвэр гаргахад гол үүрэгтэй оролцдог билээ.

Иргэдийнх нь бизнесийн суурь ур чадвар нэмэгдэж байгааг нутгийн удирдлагууд өндрөөр үнэлж, талархалтай хүлээн авч байлаа. Тэд бизнесийн ур чадвар хөгжүүлэх үйлчилгээг төрийн үйлчилгээтэй уялдуулах талаар хөтөлбөрөөс баримталсан стратегийг хэрэгжүүлэхэд санаачилгатай хандсан байв. Энэ нь нэгэнт бий болсон үйлчилгээ МАПС төсөл дууссаны дараа ч үргэлжилнэ гэсэн найдвар төрүүлж байна. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд сумын түвшинд бэлтгэгдсэн БЭХ хөтөлбөрийн сургагч багш нарыг аймгийн бизнесийн хөгжлийн үйлчилгээтэй харилцаа холбоотой болгосон нь цаашид үйлчилгээний тогтвортой байдлыг хангахад дэмжлэг болох буй за.

Гэвч бэлтгэгдсэн багш нар өөр газар луу шилжин суурьших, өөрчлөгдөх, түүнчлэн улирлын чанартай бэлчээр сэлгэлт, зээлийн эх үүсвэрийн хомсдол зэргийн улмаас малчид, сумын иргэдийн дундах бизнес эрхлэлтийн сургалт, зөвлөгөөний эрэлт хэрэгцээ буурах зэрэг нь бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээг тогтмолжуулахад нөлөөлж болзошгүйг нутгийн удирдлагууд анхааралдаа авах нь зүйтэй. Тиймээс бизнес хөгжүүлэх үйлчилгээний эрэлт хэрэгцээнд гарах хэлбэлзлийг харгалзан үзсэн стратегийг боловсруулах шаардлагатай байж болзошгүй.

Бүтээмжтэй хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа тэтгэхийн төлөө залуу малчдын ур чадварыг хөгжүүлэв

Сүргийн менежмент, ашиг шимийг сайжруулах, малчдын орлого, амьжиргааг дээшлүүлэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс баримталж буй бодлогыг хэрэгжүүлэхэд олон арга хэмжээ шаардлагатай байгаагийн нэг нь малчдын ур чадварыг хөгжүүлж, сэтгэлгээг өөрчлөх замаар бүтээмжийг өсгөх явдал юм. Малын ашиг шимийг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн борлуулахаас илүү малынхаа тоо толгойг өсгөхөд түлхүү анхаарч байгаа малчид олон бий. Малын тоо толгой өсөх нь бэлчээрийн чанар, даацад сөргөөр нөлөөлж байна.

Иймд туршилтын хөтөлбөр нь залуу малчдын бэлчээрийн мал аж ахуй эрхлэх арга ухааныг нэмэгдүүлэх, залуу малчид, хоршооны гишүүдийн түүхий эд боловсруулах чадавхийг сайжруулахад анхаарч ажиллажээ. Түүхий эдийг сайтар боловсруулж борлуулбал малчид, хоршооны гишүүд илүү орлого олох боломжтой. Хөтөлбөрөөр сүү, ноос, арьс шир, мах зэрэг үндсэн бүтээгдэхүүнийг боловсруулах арга аргачлалд сургах 5 хоногийн сургалт зохион байгуулж залуу малчид, хоршооны гишүүдийг хамруулсан байна. Сум бүрт зохион байгуулагдсан энэхүү дөрвөн төрлийн сургалтад нийт 87 хүн оролцсоноос 67 хувь нь эмэгтэйчүүд байв.



Орон нутгийн холбогдох талууд эдгээр дөрвөн төрлийн сургалтыг нэн тэргүүнд хэрэгцээтэй гэж тодорхойлсон аж. Зах зээлд тавигдаж буй шаардлага болон дээрх дөрвөн төрлийн түүхий эдийг боловсруулахад малчдын ашигладаг арга туршлагын хооронд нэлээд зөрүү байгааг үндэсний зөвлөхийн хийсэн судалгаагаар илрүүлсний үндсэн дээр сургалтын хөтөлбөрүүдийн агуулгыг боловсруулсан байна. Дээр дурдсан дөрвөн төрлийн бүтээгдэхүүний төрөлжсөн сургалтуудыг сумын төвд зохион байгуулж, Улаанбаатараас урьж авчирсан мэргэжилтэн багш нараар заалгажээ. Сургалтын хугацааг тухайн түүхий эд-бүтээгдэхүүн гардаг улиралтай уялдуулсан тул сурсан зүйлээ амьдрал дээр туршиж үзэх боломжийг малчдад олгожээ. Сургалтыг бусад малчдад зохион байгуулахын тулд сумдын Насан туршийн боловсролын төвийн арга зүйчийг мөн сургалтад оролцуулж чадавхжуулсан байна.

Туршилтын хөтөлбөрийн дунд хугацааны дотоод үнэлгээгээр дээрх сургалтууд оролцогчдод ямар нөлөө үзүүлснийг тогтоожээ. Тус үнэлгээнээс харахад залуу малчид түүхий эд боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр эзэмшсэн шинэ ур чадвараа ашиглан нэмэлт орлого олох боломжийг эрэлхийлэхдээ илүү итгэлтэй болсон аж. Мөн энэхүү сургалт нь хөдөө нутагт мартагдаж байгаа, зарим нь аль хэдийн мартагдсан уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга ухааныг сэргээхэд тусалжээ.

Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга Баттулга: “Ур чадвар хөгжүүлэх сургалт нь анхан шатны боловсруулалт хийж бүтээгдэхүүнээ арай илүү үнээр борлуулах боломжийг нэмэгдүүлсэн; зарим бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийх уламжлалт аргыг сэргээхэд тусалсан; залуу малчдад тэдний нөөц бололцоог таниулж, зах зээлээс худалдаж авдаг зүйлээ өөрсдөө хийх, цаашлаад худалдаж борлуулан орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжтойг нь ойлгуулсан; иргэдийн хамтдаа бизнес хийх сонирхлыг өдөөсөн давуу талтай байв.”

Ерөнхийд нь дүгнэж хэлэхэд, сургалтын үр дүнд залуу малчид өөрсдөд нь байгаа боломжоо илүүтэй сайн олж хардаг болжээ. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалтуудыг мэргэжилтэн багш заасан, чанартай (аж ахуй эрхлэлтийг ур чадварын хөгжилтэй хослуулсан) практик сургалт болсон гэдгийг залуу малчид талархан тэмдэглэсэн байна.

Манлайбаяр бол Баянхонгор аймгийн Галуут сумын “Хот мандал ундарга” хоршооны гишүүн. Тэрээр зөвхөн өөрийн адууны уналга эдэлгээнд зориулж суран эдлэл хийдэг байжээ. Манлайбаяр сургалтад хамрагдаж сур элдэх шинэ технологи эзэмшсэндээ баяртай байна. Мартагдах шахсан уламжлалт аргаар чөдөр ногт зангидаж сурсан байна. Бүтээгдэхүүнийх нь чанар сайжирсан тул ашиг орлого нь нэмэгдэх нь дамжиггүй. Сургалтын дараа тэрээр бусад оролцогчидтой хамтран зах зээлд хамгийн эрэлттэй байгаа арьс шир, суран эдлэл үйлдвэрлэхээр шийджээ.



Хөтөлбөрөөс зохион байгуулсан бизнес эрхлэх, ур чадварын сургалтад оролцогчдын чадавх сайжирсан нь нутгийн удирдлагуудын дэмжлэгийг тэдний зүг хандуулахад хүргэсэн байна. Өмнө дурдсанчлан нутгийн удирдлагуудын зүгээс залуу малчдад зориулж тоног төхөөрөмж олгох, хоршооны гишүүдийн дундын хэрэглээнд ажлын байр, талбай гаргах зэргээр мөнгөн бус тусламж үзүүлэх, мөн бизнес төслөө хэрэгжүүлэх, малын хашаа хороо барихад нь зориулсан хөнгөлөлттэй зээл олгох зэргээр дэмжиж эхэлжээ.

Оюунцэнд бол Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын “Чулуут тээл” хоршооны гишүүн. Урьд нь тэрээр зөвхөн гэр бүлийнхээ хэрэгцээнд зориулж ноосон оймс урладаг байжээ. Тэрээр туршилтын хөтөлбөрийн ноос боловсруулах, ноосон эдлэл хийх сургалтад хамрагдаж шинэ арга техник сурч авсан байна. Сургалтын дараа “Сум хөгжүүлэх сан”-д хандаж 1.5 сая төгрөгийн зээл авчээ. Одоо Оюунцэнд бүтээгдэхүүнээ өөрийн төдийгүй зэргэлдээ баг, сумын иргэдэд борлуулдаг болжээ.

Түмэнжаргал бол Баянхонгор аймгийн Галуут сумын “Агдуут булаг” хоршооны гишүүн. Тэднийх 2010 оны зуднаар ихэнх малаа алдсанаас хойш өрхийнхөө наад захын амьжиргааг залгуулахад хэцүү болсон байна. Түмэнжаргал сумын төвд ажил хайсан боловч олсонгүй. Харин ОУХБ-ын туршилтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан ноос боловсруулах, ноосон эдлэл үйлдвэрлэх болон бизнесийн сургалтад хамрагдах боломж олджээ. Сургалтын үр дүнд ноосоор хүүхдийн малгай, оймс, гэрийн шаахай, бэлэг дурсгалын зүйл хийж сурчээ. Сумын Засаг даргын Тамгын газраас түүнд ноос самнах төхөөрөмж олгож, бусадтай дундаа хэрэглэх ажлын өрөө гаргаж өгчээ. Түүний бүтээл аймгийн хэмжээнд жил бүр зохион байгуулагддаг “Нэг баг - Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэнд сонгогдож, “Шилдэг бүтээгдэхүүн”-ий шагнал хүртсэн байна. Тэрээр орлогоо нэмэгдүүлэх боломжоо өргөжүүлэх зорилгоор “Сум хөгжүүлэх сан”-гаас 2 сая төгрөгийн зээл авчээ. Түүнээс хойш өрхийн орлого нь нэлээд нэмэгдсэн байна. Түмэнжаргал одоо бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг олшруулж, жуулчны улиралд зориулж бэлэг дурсгал хийхэд анхаарч байна.

Сургалтын үр нөлөө нь дан ганц сургалтад оролцогчдоор хязгаарлагдалгүй хоршоодын хөгжилд ч зарим нааштай нөлөө үзүүлснийг туршилтын хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээний явцад болон хөтөлбөрийн төгсгөлд орон нутгийн холбогдох талууд дурдсан байна. Сайн чанартай, хэрэгцээнд нийцсэн ур чадварын сургалтад хамрагдах боломж олгосон, цаашид хоршооны бизнесийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж болзошгүй шинэ бизнесийн санаачилгыг дэмжсэн гэх зэргээр гишүүд нь хоршоогоо үнэлсэн байлаа. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд сумын удирдлага хоршоодтой хамтран ажилласнаар малчдын хоршоог дэмжих хэрэгцээ шаардлагын талаар орон нутгийн засаг захиргаа илүү ойлголттой болсон байна.

Хөтөлбөрөөс зохион байгуулсан сургалтууд малчдын сургалтын талаарх орон

нутгийнхны хандлагыг, тухайлбал, малчид малаасаа удаан хугацаагаар хол байх боломжгүй, тэд нэг өдрөөс дээш хугацаатай сургалтад суух сонирхолгүй гэсэн ойлголтыг нь өөрчилжээ. Амьжиргаагаа дээшлүүлэхэд нь тус болох сургалтад малчид үнэхээр ач холбогдол өгдөг гэдгийг туршилтын хөтөлбөр бэлхнээ харуулсан байна. Хэрэгцээнд нь нийцсэн, өндөр чанартай, газар нутгийн хувьд дөт зохион байгуулагдсан сургалт малчдад урьд өмнөх сургалтуудаас өөр санагджээ.

Ийм сургалтууд хоршооны бизнесийг хөгжүүлэх, нэмүү өртгийн сүлжээнд малчдын үйлдвэрлэлийг нэгтгэх, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дунд болон урт хугацааны нөлөө үзүүлэх ирээдүйтэй юм. Эдгээр сургалтын туршлагаас бодлогын нөлөөтэй хэд хэдэн асуудлууд урган гарч ирж байна. Тухайлбал, малчдад зориулсан сургалтын тогтолцоо, чанарын баталгаажуулалтын механизм, малчид, тэдний хоршооны хэрэгцээнд нийцсэн, өндөр чанартай сургалт зохион байгуулах чадавхийг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна. Малчдыг сургах тогтолцоо, сургалт зохион байгуулах чадавхийг бүрдүүлэх нь хөдөө орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах, хөдөө аж ахуйн хоршоо ба экспортод чиглэсэн дотоодын үйлдвэрлэлийн хөгжлийн уялдааг хангах зэрэг Засгийн газрын бодлогын тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй юм.

Малчид түүхий эдээ бодит үнээр борлуулж чадахгүй байна. Саяхан байгуулагдсан “Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн бирж”⁶ болон малчдад төрөөс олгодог ноос, арьс ширний урамшуулал нь бодлогын өөрчлөлтийн дохио юм. Цаашид малчид боловсруулсан түүхий эдээ арай илүү үнээр борлуулахад нь хоршоо чухал үүрэг гүйцэтгэдэг болох нь дамжиггүй.

Залуу малчдын бие даан суралцахуйг дэмжив



Малчдын амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй учраас бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг авч үлдэхийн сацуу малын эрүүл мэнд, вакцинжуулалт, үржлийн чанарыг сайжруулах, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах зэрэг орчин үеийн шаардлага, зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан хөгжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Монгол Улсын ихэнх нутаг дэвсгэр эрчимжсэн аж ахуй эрхлэхэд тохиромжгүй. Иймд бэлчээрийн мал аж ахуй нь тус улсын хөдөө орон нутгийн эдийн засаг, хүнсний баталгаат байдал, эдийн засгийн интеграцчиллын үндэс хэвээр байх болно.

Туршилтын хөтөлбөрт залуу малчдын мал маллах арга ухааныг хөгжүүлэх зорилт тавьжээ. Энэ хүрээнд ОУХБ-ын өмнөх нэгэн төслөөр боловсруулсан “XXI зууны малчин”⁷ хэмээх бие даан суралцах, хэрэглэхэд хялбар багц гарын авлагыг дахин хэвлэж залуу малчдад түгээн судлуулсан байна. Тус багц нь бэлчээрийн мал аж ахуйн нэн чухал асуудлуудыг тусгасан 9 модулиас бүрддэг. Уг гарын авлагыг олсон мэдлэгээ практикт туршиж үзэн өөртөө үнэлгээ өгөх хяналтын хуудас, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хуанли, өрхийн санхүүгийн бүртгэлийн дэвтрийн загвар зэрэг дагалддаг.

Хоршооны дарга нар гарын авлагыг уншиж судлахад нь залуу малчин гишүүддээ дэмжлэг үзүүлж, орон нутгийн удирдлагын төлөөлөгчийн хамт суралцах явцад нь хяналт тавьж байв. Жишээлбэл, Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд малчдын суралцах явцыг үр дүнд суурилсан зохицуулалтын хэлбэрээр дэмжсэн байна. Тухайлбал, гарын

6 Түүхий эдийн агуулах, чанарын баталгаажилт, гэрчилгээжүүлэлт, тээвэрлэлт зэрэгт оролцдог байгууллага, үйлчилгээний үүрэг, ажиллагааг сайжруулах, зохицуулах үйл явц

7 Малчдад нэн шаардлагатай мэдлэг чадварыг хөгжүүлэх зорилготой сургалтын энэхүү багцыг 2012-2013 онд ОУХБ-ын “Хөдөөгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд боловсруулсан юм.

авлагыг амжилттай судлуулахын тулд залуу малчин, зөвлөх малчин, хоршооны дарга, Засаг даргын тамгын газрын хооронд дөрвөн талт гэрээ байгуулж, малчин өрхүүдээр тогтмол очин бие даасан сургалтын явцад хяналт тавьж байжээ.

“XXI зууны малчин” гарын авлага нь бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ухаан болон мал аж ахуйд тавигдаж буй орчин үеийн шаардлагын талаар залуу малчдын мэдлэгийг дээшлүүлэхэд чухал эх сурвалж болсон нь нотлогдсон байна. Ийм сургалтын дунд болон урт хугацааны нөлөөг үнэлж баршгүй юм. Туршилтын хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээний үеэр хөтөлбөрт хамрагдсан малчид гарын авлагыг хэрэгцээнд нь нийцсэн, тустай зүйл болсныг тэмдэглэж, хөтөлбөрт хамрагдаагүй малчид ч гэсэн тэднээс авч уншиж байсныг дурьдсан байна. Тус гарын авлага нь мал аж ахуйн асуудлаар тулгардаг олон асуултад хангалттай хэмжээнд хариу өгөх чадамжтай гэж залуу малчид дүгнэсэн ажээ.

Б.Үүрмандах бол Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын “Асгана өндөр” хоршооны гишүүн, залуу малчин. Тэрээр “XXI зууны малчин” гарын авлагыг ашиглан бэлчээрийг зохистой ашиглах, өвлийг өнтэй давах, ган гачигтай үеийн малын арчилгаа, маллагаа, хашаа хороо барих талаар их зүйл сурч мэдсэн байна. Бизнес сургалтад хамрагдсанахаа дараа өвөлжөөгөө өргөтгөх зорилгоор “Сум хөгжүүлэх сан”-д төсөл бичиж, 3 жилийн хугацаатай 2 сая төгрөгийн зээл авчээ. Хашаа хороо хэрхэн барих тухай мэдээллийг “XXI зууны малчин” гарын авлагаас мөн олж авсан байна. “Орон нутгийн бизнесийн хөгжил” гарын авлагаас данс тооцоо хэрхэн хөтлөх талаар суралцсанаар малынхаа ашиг шимийг нэмэгдүүлэх сонирхолтой болжээ.

Малчны сургалтад бие даан суралцах аргачлалыг ашиглах боломжтойг туршилтын хөтөлбөрийн үр дүнгээс харж болно. Бие даан суралцах гарын авлага нь янз бүрийн насны малчдын дунд эрэлт ихтэй болсон, малчид ийнхүү сурсан мэдсэнээ ашиглан амьжиргаагаа сайжруулах боломж байгааг харгалзан МАПС төслийн зүгээс Хөдөлмөрийн яаманд хандаж, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд тус гарын авлагыг улсын хэмжээнд түгээх асуудлыг судалж үзэхийг санал болгожээ. Үүний дагуу тус яамнаас туршилтын хөтөлбөрт хамрагдсан хоёр аймгийн бүх сумдад уг гарын авлагыг тарааж судлуулан үр дүнг нь судлах ажлыг эхлүүлээд байна.

“XXI зууны малчин” бие даан суралцах багц болон хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан бусад гарын авлагууд, тухайлбал, сүү, ноос, арьс шир, мах боловсруулах, орон нутагт бизнес хөгжүүлэх, нийгмийн даатгалын талаар ойлголт нэмэгдүүлэх гарын авлагуудыг МАПС төслөөс хангалттай тоогоор Хөдөлмөрийн яаманд хүлээлгэж өгсөн байна.

Туршилтын хөтөлбөрийн үйл ажиллагаа, түүний дотор залуу малчдын бие даан суралцах боломжийг туршсан үр дүнд тулгуурлан Хөдөлмөрийн яам уг бие даан суралцах багц материалыг “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдах бүх аймгийн малчин өрхүүдэд түгээх асуудлыг шийдвэрлэх ажээ.

Ирээдүйгээ харахуй: Малчдын амьжиргааг дээшлүүлэхэд хоршооны гүйцэтгэх үүрэг

Малчдын орлого, амьжиргааг дээшлүүлэхэд хоршоо чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Гэвч төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооны үед өрнүүлсэн нэгдэлжих хөдөлгөөний талаарх иргэдийн дундах сөрөг хандлага нь тус улсад малчдын хоршоог хөгжүүлэхэд чөдөр тушаа болж байна. Хоршоонд итгэх малчдын итгэл сул байгаа нь малчдад үр шимээ өгөх боломжтой хоршооны хөгжлийг тушиж байна.

Төрөөс хоршоодыг дэмжиж, чадавхжуулах бодлого баримталж байна. Мөн Засгийн газраас хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийн бирж байгуулж, хоршоо өөрсдөө болон сонгосон зуучлагчаараа дамжуулан малын гаралтай түүхий эд, боловсруулсан бүтээгдэхүүнээ арилжих боломжийг бүрдүүлэхээс гадна хоршооны гишүүдэд төрөөс

ноос, арьс ширний урамшуулал олгодог болов. Ийнхүү хөдөөг хөгжүүлэхэд хоршоодын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд төрөөс анхаарч байна. Гэвч малчдын хоршоо шинэ тогтолцооны үр шимийг бүрэн хүртэж чадахгүй хэвээрээ байна. Хоршооны удирдлагын чадавх сул, хөрөнгийн хуримтлал бага, гишүүдийн харилцан итгэлцэл, хамтын ажиллагаа дутмаг байгаа нь хоршооны хөгжил, боломжийг хойш чангааж байна.



Туршилтын хөтөлбөр нь малчдын хоршоодын гишүүддээ үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэхэд анхаарч ажилласан бөгөөд олон үйл ажиллагаа нь хоршоог чадавхжуулах, нэр хүндийг нь дээшлүүлэхэд чиглэгджээ. Тухайлбал, сумын түвшинд бизнес эрхлэх сургалт, бизнесийн зөвлөх үйлчилгээ бий болгох, хоршооны гишүүдэд зориулсан бизнес эрхлэх болон ур чадварын сургалт, нийгмийн даатгалын ач холбогдлыг малчдад ойлгуулах ажлыг хоршоодтой нягт хамтран зохион байгуулсан аж. Туршилтын хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээгээр малчдын амьжиргааг дээшлүүлэхийн тулд хоршооны менежментийн чадавхийг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэр, зах зээлтэй холбогдох боломжийг нэмэгдүүлэх нь чухал гэж дүгнэж, хөтөлбөрийн зүгээс энэ чиглэлээр анхаарч ажиллах хэрэгтэйг онцолсон байна.

Тиймээс энэ асуудалд хөтөлбөрийн зүгээс анхаарч, хоршооны дарга, гишүүдэд зориулсан хэлэлцээ хийх, маркетингийн болон харилцаа, менежментийн ур чадвар эзэмшүүлэх цогц сургалт хэрэгтэй байгаа, эдгээр ур чадвар нь хоршооны өмнө тулгамддаг олон асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзсэн байна.

Ийнхүү МАПС төсөл ОУХБ-ын “Манай хоршоо – Хөдөө аж ахуйн хоршоог удирдах нь” сургалтын хөтөлбөрийг Монгол Улсад нэвтрүүлсэн ажээ. Үүний тулд “Манай хоршоо” сургалтын модулийг орчуулж, Монголын малчдын хоршооны онцлогт нийцүүлэн өөрчилж, 25 сургагч багш(үүнээс 69 хувь нь эмэгтэй)-ийг бэлтгэсэн аж. Тус хоёр аймгаас нийт 22 хүн, тухайлбал хоршоодын дарга, гишүүдийг хамруулснаас 45 хувь нь эмэгтэйчүүд байв. Эдгээр үйл ажиллагааг Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо (МХААХҮХ) болон Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төв (МХСМТ) хамтарч зохион байгуулсан байна.

“Манай хоршоо” сургалт нь Монголын хоршоодын чадавхийг цогцоор нь хөгжүүлэх хэрэгцээнд бүрэн нийцжээ. Тус сургалт нь хоршооны менежмент, нэмүү өртгийн сүлжээ, бизнес хөгжил зэрэг хөдөө аж ахуйн хоршоотой холбоотой бүхий л асуудлуудыг багтаасан учраас сургагч багшийн сургалтад оролцогчид ихэд талархалтай хүлээж авснаа илэрхийлсэн байна. Эдгээр нь Монголын хөдөө аж ахуйн хоршоодод үнэхээр

амин чухал юм. МХААХҮХ ба МХСМТ-ийн төлөөлөгчид сургалтад ашигласан идэвхтэй, суралцагч төвтэй арга зүйг сайшааж, хоршооны менежментийн талаар зохион байгуулж буй бусад сургалтуудаас хамгийн дэвшилтэт нь хэмээн онцолж байв.

Энэхүү сургалтын хөтөлбөр нь Монголын хөдөө орон нутагт хоршоог хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах бололцоотой. Гишүүддээ хэрэгцээтэй үйлчилгээ үзүүлдэг, чадварлаг удирдлага, зохион байгуулалт бүхий хоршоо нь гишүүдийнхээ хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тэдэнд хоршооны ач холбогдлыг илүүтэй ойлгуулдаг. “Манай хоршоо” сургалтын хөтөлбөр, түүнчлэн амжилттай ажиллаж байгаа малчдын зарим хоршооны туршлагад тулгуурлан МХААХҮХ-ноос орчин үеийн малчдын хоршооны загвар боловсруулахаар төлөвлөж байна.

Хөдөөгийн залуучуудын ур чадвар, орлогын баталгааг дэмжихэд чиглэсэн орон нутгийн чадавхийг дээшлүүлэв

Малчдын амьжиргааг сайжруулахаас гадна МАПС төслийн туршилтын хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төрийн байгууллагуудын чадавхийг сайжруулах хэд хэдэн үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлжээ. Хоёр аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсийн ажилтнуудад хийсэн сургалтууд хөтөлбөрийн үр дүнд тодорхой нөлөө үзүүлсэн гэж орон нутгийнхан үзсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулахад анхаарав

Зарим малчид орлогоо нэмэгдүүлэхийн тулд өөр салбарт ажил эрхлэх сонирхолтой байдгийг туршилтын хөтөлбөрийн төлөвлөлтийн үе шатанд сонгогдсон сумдад хийсэн нийгэм, эдийн засгийн байдлын үнэлгээгээр тодорхойлсон байна. Тэдний зарим нь дулааны улиралд өөр ажил эрхэлдэг бол зарим нь сум, аймгийн төвд ажил хайж ирдэг байна. Тиймээс энэхүү төсөл нь өөр салбарт хөдөлмөр эрхлэх сонирхолтой залуучуудад туслах зорилт тавьсан ажээ. Ажил хайж ганцаараа болон гэр бүлийн хамт өөр газар нутаг руу шилжин суурьшихаар төлөвлөж буй залуучуудад очих газрын орчин нөхцөл, шинээр суурьших, амьдрахтай холбоотой чиглүүлэг, мэдээлэл хэрэгтэй байдаг. Ийм чиглүүлэх, зөвлөх үйлчилгээг хөдөлмөр эрхлэлтийн мэргэшсэн зөвлөхүүд өгөх ёстой.

Туршилтын хөтөлбөрийн хүрээнд зорилтот хоёр аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн ажилтнуудад зориулж хоёр хоногийн чадавх бэхжүүлэх сургалтыг 2015 оны 10 дугаар сард зохион байгуулжээ. Энэ сургалт нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чиг үүрэг, үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийн чанартай үйлчилгээний хүртээмж, хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрүүдийг залуучууд гэх мэт янз бүрийн зорилтот бүлгийн онцлогт нийцүүлэх шаардлагын талаар оролцогчдын ойлголтыг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулсан байна. Сургалтад оролцсон 41 ажилтны 85 хувь нь эмэгтэйчүүд байв.

Тус сургалт нь Хөдөлмөрийн яамнаас хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудын чадавхийг бэхжүүлэхэд зориулсан улсын хэмжээний нийтлэг хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой байв. Ялангуяа 2015 оны эхээр Монгол Улсын нэгдэж орсон ОУХБ-ын Төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай 1948 оны 88 дугаар конвенц болон Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай 1997 оны 181 дүгээр конвенцийг хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор дээрх сургалтыг зохион байгуулжээ.

Сургалтын явцыг ажиглаж, сургалтын хөтөлбөрийг судалж үзсэний үндсэн дээр Хөдөлмөрийн яамны холбогдох албан тушаалтнууд сургалтын хөтөлбөрт зарим өөрчлөлт хийж, бусад нутаг оронд түгээн дэлгэрүүлэх нь зүйтэй гэж шийдсэн байна. Тэд Хөдөлмөрийн хэлтсийн ажилтнууд бие даан суралцах онлайн сургалтын модуль боловсруулах санал дэвшүүлжээ. Хэд хэдэн удаагийн уулзалтын үр дүнд Хөдөлмөрийн хэлтсийн ажилтнуудад зориулсан сургалтын цогц гарын авлага боловсруулах нь зүйтэй гэдэг дээр санал нэгдсэн ч цаг хугацааны давчуу байдлын улмаас төслийн зүгээс энэхүү санаачилгыг бүрэн гүйцэлдүүлж чадсангүй. Гэвч МАПС төсөл дууссаны дараа ОУХБ-аас энэхүү хүчин чармайлтыг үргэлжлүүлэн дэмжихэд анхаарч ажиллахаар тохирчээ.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавх бэхжүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг цогц байдлаар хэрэгжүүлнэ гэж МАПС төсөлд анхнаасаа төлөвлөгдөөгүй байсан тул шаардлагатай эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадсангүй. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний дэс дараалал, үйл ажиллагаанд баримтлах журмыг боловсруулж хэрэгжүүлэх, залуучууд болон бусад зорилтот бүлэгт тохирсон аргачлалыг хөгжүүлэх зэргээр хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавхийг цогц байдлаар сайжруулах хэрэгцээ маргаангүй тулгамдсан асуудал болжээ.

Нийгмийн даатгалын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэв

Малчид нийгмийн даатгалд хамрагдсанаар орлогын баталгаа нь сайжирна. Өвчлөх, осолд орох, жирэмслэх, амаржих, өндөр наслах зэрэг хүний амьдралд жам ёсны болон гэнэтийн байдлаар тохиолддог үйл явдлууд нь тухайн хүний хөдөлмөр эрхэлж, орлого олох чадварыг нь бууруулж, санхүүгийн хохирол учруулдаг. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор нь эдгээр тохиолдолд орлогын алдагдлыг нөхөж, бизнесээ хамгаалахад нь тусалдаг. Малчдын хувьд нийгмийн даатгалд хамрагдах нь хөдөлмөрийн насандаа төдийгүй нас өндөр болсон үедээ орлогын баталгаатай байх чухал стратеги юм. Гэвч Монгол Улсад малчдын нийгмийн даатгалд хамрагдалт бага байна. 2013 онд малчдын 9.1 хувь нь л сайн дурын нийгмийн даатгалд хамрагдаж байсан бөгөөд 2015 оны эцэс гэхэд дөнгөж 10.4 хувь болж өсчээ. Иймд хамралтыг нэмэгдүүлэх асуудал Засгийн газрын бодлогын тэргүүлэх чиглэл болоод байна.



Малчид нийгмийн даатгалд хамрагдахгүй байгаа гол шалтгаанаа орлого бага, нийгмийн даатгалын ач холбогдлыг ойлгохгүй байгаатай холбожээ. Бизнесийн болон ур чадварын сургалт зохион байгуулах, нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулж, ойлгуулах замаар малчдыг аж ахуйн чадамжтай болгож орлогын баталгааг хангах нь туршилтын хөтөлбөрийн стратегийн салшгүй нэг хэсэг байв. Нийгмийн даатгалд даатгуулах журмыг хялбаршуулж, шимтгэл төлөх үйл ажиллагааг уян хатан байдлаар зохион байгуулах нь малчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх болно.

МАПС төсөл нь хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэхээс гадна эмзэг бүлэгт нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр Засгийн газар, нийгмийн түншүүдийг чадавхжуулахад анхаарсан байна. Энэ хүрээнд Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшнийг тодорхойлох, шаардагдах зардлыг тооцох асуудлаар үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр мэдлэг, бодлогын зөвлөлдөөнийг дэмжсэн нэлээд үйл ажиллагаа хэрэгжүүлсэн ажээ. МАПС төслийн зүгээс нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны бүх үр дүнг энэхүү тайланд дурдах

зорилго агуулаагүй. Гэхдээ төслийн зүгээс үндэсний түвшинд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь малчдын нийгмийн даатгалын талаарх ойлголтыг дээшлүүлэх, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх гэсэн туршилтын хөтөлбөрийн зорилттой бодлогын талаасаа шууд уялдаж, нөлөө үзүүлснийг дурдах нь зүйтэй.

2014 оны 10 дугаар сар болон 2015 оны 9 дүгээр сард хоёр аймагт зохион байгуулсан нийгмийн даатгалын ажилтнуудын чадавх бэхжүүлэх сургалтууд нь тэдний хандлага, арга барил, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах замаар эмзэг бүлгийнхний сайн дурын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилго тавьсан ажээ. Эдгээр сургалтад нийтдээ 176 хүн хамрагдсанаас 64 хувь нь эмэгтэйчүүд байв.

Одоогийн сайн дурын нийгмийн даатгалын хувьд ч, цаашид 2015 оны 6 дугаар сард батлагдсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсаны дагуу төрөөс шимтгэлд нь дэмжлэг үзүүлэх замаар албан журмын даатгалын тогтолцоо нэвтрүүлсэн нөхцөлд ч нийгмийн даатгалын байгууллагын сурталчлан таниулах чиг үүрэг чухал ач холбогдолтой хэвээр байна. Тиймээс МАПС төсөл нь улс орны хэмжээнд малчид, залуучуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажилд хэрэглэх энгийн ойлгомжтой гарын авлага, материал боловсруулахад нь Нийгмийн даатгалын ерөнхий газар(НДЕГ)-т дэмжлэг үзүүлжээ.

Малчдад зориулсан нийгмийн даатгалын тухай бие даан суралцах гарын авлагад нийгмийн даатгалын таван төрөл, түүний дотор эрүүл мэндийн даатгалын мэдээллийг багтаажээ. НДЕГ-ын хувьд тус гарын авлага нь ийм төрлийн анхдагч бүтээл болж, малчдын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд үйлчлүүлэгч төвтэй арга зүйг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болсныг онцлон тэмдэглэсэн байна.



Туршилтын хөтөлбөрт сонгогдсон хоёр сумын малчдын мэдлэг, мэдээллийг зузаатгахад нийгмийн даатгалын ажилтнуудын идэвх оролцоо нэмэгджээ. Тэд мэдээлэл түгээхдээ малчдын цуглаан, уулзалтуудыг ашигладаг болсон байна. Туршилтын хөтөлбөрт хамрагдсан хоршоод ч мөн адил нийгмийн даатгалын талаарх мэдээллийг гишүүд, залуучууддаа түгээхэд дэмжлэг үзүүлжээ.

Хөтөлбөрт хамрагдсан залуу малчид нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдлыг ойлгож мэдсэнийг тэдний сайн дурын нийгмийн даатгалд хамрагдалт нэлээд нэмэгдсэнээс харж болно. Туршилтын хөтөлбөрийн эхэнд Галуут сумын зорилтот 90 малчны 7 нь нийгмийн даатгалтай байсан бол 2016 оны 6 дугаар сарын дунд гэхэд 45 болж өсчээ. Нарийнтээл суманд энэ тоо 22-оос 45 болж өссөн байна. Гэхдээ энэ өсөлтийг дан ганц туршилтын хөтөлбөртэй холбон тайлбарлаж болохгүй. Учир нь малчид банкнаас бага хүүтэй зээл авахад нийгмийн даатгалд хамрагдсан байх шаардлага тавих болсон нь нөлөөлсөн байж болзошгүй. Түүнчлэн 2014 оноос 2016 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд нийгмийн даатгалд хамрагдагсдын тоо Галуут суманд 192-оос 495, Нарийнтээл суманд 390-ээс 732 болж өсчээ.

Туршилтын хөтөлбөрийн туршлагаас харахад нийгмийн даатгалын ажилтнууд малчдын хоршоодтой алсын хараатай хамтарч ажиллах шаардлагатай байна. Дунд хугацааны үнэлгээгээр илрүүлсэн нэг асуудал бол сонгогдсон хоёр сумын нэгнийх нь нийгмийн даатгалын ажилтан малчдын хоршоодод үндэслэлгүй шаардлага тавьж байсан явдал байв. Тэрээр малчдын хоршооны бүх гишүүдийг нийгмийн даатгалд заавал хамрагдаж шимтгэл төлөхийг шаардсан байна. Энэ нь төрийн албан хаагчид хоршооны мөн чанарыг зөв ойлгож, түншлэлийн стратеги баримталж ажиллах шаардлагатай байгааг тод харуулж байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ДҮГНЭЛТ

МАПС төслийн хөдөө орон нутгийн залуучуудад чиглэсэн туршилтын хөтөлбөр нь залуу малчдын бүтээмжтэй хөдөлмөр эрхлэх, орлогын тогтвортой баталгаа бүрдүүлэх боломжийг нь нэмэгдүүлэх, түүнчлэн малчдын хоршооны үнэлэмж, ач холбогдлыг дээшлүүлэхэд анхаарч, хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжилд тулгардаг сорилтуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлжээ.

Тус туршилтын хөтөлбөрийн хүрээнд (i) малчдад бизнес эрхлэх сургалт, ур чадвар олгох чадавх, үйлчилгээ сумын түвшинд дутмаг; (ii) малчдын амьжиргаа, нийтлэг ашиг сонирхлыг дэмжихэд хоршоодын үүргийг нэмэгдүүлэх шаардлага; (iii) нийгмийн даатгалаар дамжуулж орлогын баталгааг бий болгох хэрэгцээ зэрэг асуудлыг шийдвэрлэхийг зорьжээ. Залуу малчид мал аж ахуйн болон бусад салбарт бүтээмжтэй, тогтвортой хөдөлмөр эрхлэхдээ олон сорилт бэрхшээлтэй тулгардаг нь тэдний ур чадвар, туршлага хангалтгүй байдагтай холбоотой. Тиймээс залуу малчдын эдгээр хэрэгцээг шийдвэрлэхэд туршилтын хөтөлбөр анхаарлаа хандуулжээ.

Ерөнхийд нь дүгнэж хэлэхэд, туршилтын хөтөлбөр нь малчдын амьжиргааг сайжруулахад чиглэсэн төрийн бодлого, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд шууд хувь нэмрээ оруулсан байна. Мөн хөтөлбөр нь “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” болон “Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дэмжсэн байна.

Хөдөөд ядуурлыг бууруулах, бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурлаас “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг 2009 онд баталсан. Тус бодлого нь малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөрөө хоршихыг урамшуулах, бэлчээрийн мал аж ахуй эрхлэх аргыг боловсронгуй болгох, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийг дэмжих замаар малчдын орлогыг нэмэгдүүлж, тав тухтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилготой юм.

“Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр(2009-2017)”-ийг Засгийн газраас 2009 онд баталсан. Тус хөтөлбөр нь хоршоог хөгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах, хоршоодыг санхүү, хөрөнгө оруулалтаар дэмжих замаар жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, хоршооны бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ, үйлчилгээг бий болгох, хоршооны сургалт, мэдээллийн нэгдсэн санг төгөлдөржүүлэх зорилготой. Хөтөлбөрийн нэгдүгээр үе шатанд малчдын хоршооны тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэхэд анхаарч байна. Хоршоодыг хөрөнгө санхүүгийн эх үүсвэрээр хангах, дэвшилтэт техник, технологи эзэмших сургалтын тогтолцоог бүрдүүлэх болон ажилтнуудыг сургаж бэлтгэхэд “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” зэрэг төрийн сангууд ач холбогдолтой болохыг энэхүү хөтөлбөрт онцолжээ.

Туршилтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалтууд нь малчдын суралцах хэрэгцээнд нийцжээ. Мал маллах, бизнес эрхлэх, ур чадвар эзэмшүүлэх, нийгмийн даатгалын талаар мэдлэг олгох сургалтын модулиуд нь малчдад тулгардаг сорилт бэрхшээл, мэдлэг, ур чадварын дутагдлыг цогцоор харснаар малчдыг чадваржуулахад бодитой дэмжлэг болж чаджээ. Түүнээс гадна малчдад зориулсан сургалтууд нь Хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж буй “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг сайжруулах боломж байгааг харуулсан байна.

Сүргийн тоо толгой цөөн, мал аж ахуй эрхлэх туршлага бага, хүүхдээ сургуульд сургахтай холбоотой зардал өсөн нэмэгдэж байгаа нь олон залуу малчдыг мал маллах уу, эсвэл төв суурин газар бараадах уу гэдэг асуултыг тавихад хүргэж байна. Ялангуяа зуд болсны

дараа энэ асуулт улам хурцаар тавигддаг. Ийм учраас залуу малчдын амьжиргааг дэмжихийн тулд тэдний мал маллах арга ухааныг сайжруулах, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эд боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх ур чадвар, аж ахуй эрхлэх арга ухааныг нь дээшлүүлэх шаардлагатай юм.

Туршилтын хөтөлбөр нь зээл авах хүсэлт гаргасан болон зээл авсан малчдын аж ахуй эрхлэх чадварыг нэмэгдүүлэхэд тусалсан байна. Орон нутгийн удирдлага, ажилтнуудын мэдээлснээр зорилтот хоёр суманд зээл авахыг хүссэн иргэдийн боловсруулсан бизнесийн төслийн чанар үлэмж дээшилсэн байна.

“Манай хоршоо” сургалт нь Монголын хөдөө аж ахуйн хоршоодын хэрэгцээнд нийцсэн сургалтын цогц хөтөлбөр болж, хөдөө аж ахуйн хоршоодыг алсын хараа, стратегия эргэн харж зөв тодорхойлох шаардлагатайг тодотгож өгчээ. Тус сургалтад оролцогчид хоршооны менежмент, нэмүү өртгийн сүлжээ, хоршооны аж ахуй эрхлэх талаар ойлголт мэдлэгтэй болсон, дутагдаж байсан мэдлэгээ олж авсан гэж “Манай хоршоо” сургалтыг өндрөөр үнэлсэн байна.

Туршилтын хөтөлбөр нь хоршооны гишүүдийн зүгээс хоршооны ач холбогдлын талаарх тогтсон ойлголтыг зөв гольдролд оруулахад нь хувь нэмэр оруулж, малчдын хоршоо болон орон нутгийн удирдлагуудын хамтын ажиллагааг бэхжүүлжээ. Орон нутгийн удирдлагууд хөдөөгийн иргэдийн амьжиргааг сайжруулах, төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад хоршоодын гүйцэтгэх үүрэг, тэдэнд тулгардаг сорилт бэрхшээлийг илүүтэй ойлгодог болсон байна. Хөтөлбөрт хамрагдсан хоршоодын гишүүддээ үзүүлэх үйлчилгээ нэмэгджээ. Галуут суманд хөтөлбөрт хамрагдсан 3 хоршоо хамгийн амьжиргаа доогуур 10 гишүүнийхээ нийгмийн даатгалын шимтгэлийг түүхий эдээ зарж борлуулсан үедээ эргэн төлөх болзолтойгоор дундын сангаасаа төлөх тогтолцоо нэвтрүүлсэн байна.

Туршилтын хөтөлбөр нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудад зориулсан сургалтын тусгай хөтөлбөр боловсруулах үндэс суурийг тавьжээ. Гэхдээ Монгол Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг боловсронгуй болгоход илүү цогц аргачлал шаардлагатай байна.

Нийгмийн даатгалын талаарх малчдын ойлголтыг дээшлүүлж, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа нь Засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй нийцэж, нийгмийн даатгалын ажилтнуудыг чадавхжуулахад давхар ач холбогдолтой болов. Малчдын мэдлэг, ойлголт сайжирснаас гадна малчдын зээлийн талаар төрөөс баримталж буй бодлогын үр дүнд хөтөлбөрт хамрагдсан залуу малчдын сайн дурын нийгмийн даатгалд хамрагдалт нэмэгджээ.

Туршилтын хөтөлбөрөөс баримталсан залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогын баталгааг хангах цогц аргачлал нь малчдын бизнес эрхлэх болон ур чадварын хөгжилд чухал нөлөө үзүүлсэн байна. Малчдын хэрэгцээнд нийцсэн, чанартай сургалт нь тэдний сэтгэлгээг өөрчлөх, залуучуудын тэмүүллийг хурцлахад хувь нэмэр оруулжээ. Сургалтад хамрагдсан малчид мал маллах арга ухаанд сайтар суралцах шаардлагатай гэдгээс гадна амьжиргаагаа тогтвортой сайжруулахын тулд бизнес эрхлэх талаар ойлголт, мэдлэгтэй болж, шинэ ур чадвар эзэмшихийн чухлыг илүүтэй ойлгодог болсон байна.

Түүнчлэн туршилтын хөтөлбөрийн “цогц аргачлал”-аас харахад малчдад тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд талуудын хамтын ажиллагаа, түншлэл, нэгдмэл алсын хараа, эрмэлзэл чухал байна.

Эцэст нь дурдалгүй өнгөрч болохгүй нэг зүйл бол туршилтын хөтөлбөр нь хөдөө орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд малчдын хоршоодын гүйцэтгэх үүргийг онцолсон явдал юм. Хэдийгээр малчдын зорилтот хоршоод бүрэн чадавхжихад эрт байгаа ч туршилтын хөтөлбөрийн хүрээнд үзүүлсэн дэмжлэгийн үр дүнд хоршооны зарчмын тухай гишүүдийнхээ ойлголтыг бэхжүүлэх сонирхол нэмэгдсэн нь эдгээр хоршоодын цаашдын амжилтад эерэг нөлөө үзүүлнэ гэж найдаж байна.

Туршилтын хөтөлбөрийн үр дүнд тулгуурлан цаашид залуу малчдын амьжиргааг сайжруулах, орлогын баталгааг хангах үйл ажиллагааг зохион байгуулахад дараах

асуудлуудыг анхаарвал зохино. Үүнд:

- Малчдын мэдлэгийг зузаатгаж, бие даан суралцах үйлийг дэмжихэд мал эмнэлэг, үржлийн асуудал хариуцсан ажилтнуудыг оролцуулах нь нэн чухал.
- Хоршооны менежментийг сайжруулах үйл ажиллагааг хоршооны бизнес, гишүүдийнх нь ур чадварыг хөгжүүлэх ажилтай нягт уялдуулахын тулд хоршоог дэмжих үйл ажиллагааг төслийн эхэн үед төлөвлөх хэрэгтэй.
- Малчдын ур чадварыг хөгжүүлэх сургалтыг тогтвортой, өргөн хүрээнд зохион байгуулахад аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо чухал үүрэгтэйг орхигдуулсан байна. Иймд цаашдын хөтөлбөрүүдэд малчдын хоршоо болон аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны уялдаа холбоог бэхжүүлэх асуудлыг авч үзэх хэрэгтэй.
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулахад туршилтын хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагаа хангалтгүй, тиймээс энэ чиглэлээр цогц үйл ажиллагаа шаардлагатай.
- Нийгмийн даатгалын ажилтнуудын хандлага, арга барилыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэх, ялангуяа малчдын хоршооны тухай зөв ойлголттой болж, малчдын хоршоодтой түншлэлийн зарчмаар зохистой хамтран ажиллахыг дэмжих шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ

Туршилтын хөтөлбөрийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх талаар дараах зөвлөмжийг Засгийн газар, нийгмийн түншүүд, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо болон холбогдох бусад байгууллагуудад хүргэж байна:

Залуу малчдын ур чадварыг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх

- Залуу малчдын амьжиргааг дээшлүүлэх боломжийг нэмэгдүүлэх талаар туршилтын хөтөлбөрийн хүрсэн үр дүнг харгалзан “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд залуу малчдын ур чадварыг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх нь зүйтэй. Үүнд:
 - а. Хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд явуулдаг чадамжид суурилсан мэргэжлийн сургалт нь үргэлжлэх хугацаа, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх шаардлага талаасаа малчдын хэрэгцээг хангахад хүндрэлтэй. Иймд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд малчдын сургалтын тусгай хөтөлбөр бий болгох нь зүйтэй. Энэ зорилгоор уг хөтөлбөрийг сургалтын бие даасан бүрэлдэхүүн хэсэгтэй болгож, түүнд хамрагдах залуу малчдын бүлгийг өргөжүүлэх, тухайлбал 150-иас дээш толгой бог малтай хэдий ч харьцангуй ядуу эсвэл ядууралд орох эрсдэлтэй гэсэн ангилалд хамаарах залуу малчдыг хамруулж болно. Хөдөлмөрийн яам энэхүү нэмэлт бүлгийг тодорхойлох боломжтой юм.
 - б. Малчдын сургалтыг хоёр хэлбэрээр зохион байгуулж болно: (i) нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн борлуулахад нь дэмжлэг үзүүлж малын гаралтай бүтээгдэхүүн(сүү, ноос, арьс шир, мах)-д анхан шатны боловсруулалт хийх ур чадвар олгох; (ii) бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадвар олгох сургалт. Дээрх хоёр төрлийн сургалтын агуулга, хэрэглэгдэхүүнийг боловсруулахдаа туршилтын хөтөлбөрийн хүрээнд бүтээгдсэн ур чадвар хөгжүүлэх 4 төрлийн гарын авлагаас ашиглаж болно. Үүнд:
 - і. Эхний сургалт нь үргэлжлэх хугацааны хувьд богино байх бөгөөд туршилтын хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан сургалтын материалыг ашиглан МХААХҮХ гэх мэт орон нутгийн байгууллагууд явуулах боломжтой. Ийм сургалтыг “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулахад илүү тохиромжтой. Мөн сургалтын хөтөлбөрийн судлагдахуунд “ХІХ зууны малчин” гарын авлагын модулиуд, бизнесийн болон нийгмийн даатгалын бие даан суралцах гарын авлагыг багтаах

шаардлагатай.

- ii. Удаах хэлбэрийн сургалтыг мэргэжлийн сургалтын байгууллага арай урт хугацаагаар зохион байгуулж болно. Орон нутгийн холбогдох талууд сургалтын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо хоршоог хөгжүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, малчдын амьжиргааг дээшлүүлэх талаар баримталж буй стратегитайгаа уялдуулбал зохино. Ийм сургалтыг бизнес эрхлэх сургалттай хослуулах, мөн зээл санхүүгийн эх үүсвэртэй холбогдох боломжтой уялдуулан цогц байдлаар зохион байгуулбал үр дүн нь улам сайжирна.
- в. Хөдөлмөрийн яамнаас (Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээлэл, судалгааны үндэсний төвөөр дамжуулан) эдгээр сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулах чадвартай байгууллагуудыг сонгон шалгаруулах нь зүйтэй (аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд ч шалгарч болно). Энэ нь сургалтын шилдэг байгууллагыг сонгоход орон нутгийн удирдлага болон хоршоодод дэмжлэг болох юм.
- г. Цаашид зээл авагсдад зориулж ур чадвар олгох, бизнес эрхлэх сургалт зохион байгуулахад "Сум хөгжүүлэх сан"-г бүрэн ашиглах хэрэгтэй.
- Туршилтын хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан ур чадвар хөгжүүлэх 4 төрлийн гарын авлагыг малчдад өргөнөөр танилцуулж хэрэглүүлэх шаардлагатай байна. Цаашдаа малчдын боловсрол, сургалтад технологийн дэвшил ашиглах асуудлыг судлаж үзэх нь зүйтэй. Хэдэн жилийн өмнө Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээлэл, судалгааны үндэсний төвөөс туршсан малчдад зориулсан цахим сургалтын материал боловсруулах зэрэг шинэлэг санал санаачилгыг амьдралд нэвтрүүлэх асуудлыг анхаарч судлах нь зүйтэй. Хөдөлмөрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, МХААХҮХ-ноос малчдад зориулсан сургалтын хамрах хүрээг өргөжүүлэхэд чиглэсэн шинэлэг, тусгайлан стратеги боловсруулах шаардлагатай байна. Малын гаралтай түүхий эдийг хэрхэн боловсруулах тухай видео хичээл боловсруулж "Малчин" телевизээр түгээхээс гадна сонирхсон байгууллагууд малчдын хоршоо, түүний гишүүдэд зориулсан сургалтад ашиглаж болно.

Сумын түвшинд бизнес эрхлэх сургалт, бизнесийн зөвлөх үйлчилгээг бий болгох

- Ур чадвар хөгжүүлэх сургалтыг аж ахуй эрхлэх сургалт болон бизнесийн зөвлөх үйлчилгээтэй хослуулбал илүү үр дүнтэй байна. Тус хөтөлбөрийн хүрээнд бизнес эрхлэх сургалт, бизнесийн зөвлөх үйлчилгээг сумын түвшинд зохион байгуулж туршихад малчдад хэрэгцээтэй, ач холбогдолтой болох нь харагдсан юм. Тиймээс:
 - а. "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан"-гийн хүрээнд зохион байгуулж байсан БЭХ хөтөлбөрийн сургагч багшийн сургалтыг сэргээж, өргөжүүлэн орон нутгийн удирдлагуудын хүсэлтэд үндэслэн сумын түвшинд аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах чадавх бий болгох.
 - б. Хэдийгээр "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-өөс аж ахуй эрхлэх сургалтад хамрагдах боломж олгож байгаа ч бодит хэрэгжилт харилцан адилгүй байна. Хөдөлмөрийн яам "Орон нутгийн бизнесийн хөгжил" бие даан суралцах гарын авлагыг "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд зохион байгуулж буй малчдын бизнес эрхлэлтийн сургалтад ашиглах нь зүйтэй.
 - в. "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-т хамрагдаж малжуулах буюу санхүүгийн дэмжлэг авах залуу малчдад аж ахуй эрхлэлтийн сургалтад заавал хамрагдах болзол тавьдаг болох нь зүйтэй.
- Нэгдсэн үндэстний байгууллагын санхүүжилттэй төслүүд, олон улсын төрийн бус байгууллагууд зэрэг аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулдаг байгууллагуудын дунд "Орон нутгийн бизнесийн хөгжил" гарын авлагыг ашиглах сонирхол нэмэгдсээр байна. Иймд ОУХБ-аас сонирхогч талуудад зориулж гарын авлагыг хэрхэн ашиглах, хуулбарлан хэрэглэх талаар зааварчилгаа боловсруулах нь зүйтэй. Уг зааварчилгаанд сургалтыг БЭХ хөтөлбөрийн эрх бүхий сургагч багшаар заалгах, сумын түвшинд БЭХ сургалт зохион байгуулах чадавх бүрдүүлэхэд анхаарах шаардлагатайг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Хөдөө аж ахуйн хоршооллын хөгжлийг дэмжих

- Хөдөө орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд хөдөө аж ахуйн хоршоодын гүйцэтгэх үүрэг, эдүгээ хоршоодын өмнө тулгарч буй олон талт сорилтыг харгалзан Засгийн газраас хоршоодын хөгжилд дэмжлэг үзүүлэх нь чухал байна. Тухайлбал:
 - а. Хоршооны менежмент, нэмүү өртгийн сүлжээнд нэгдэх, маркетинг, гэрээ хэлцэл хийх чадварын талаар малчдын хоршооны ойлголт, чадавхийг дээшлүүлэх.
 - б. МХААХҮХ, МХСМТ-өөс “Манай хоршоо – Хөдөө аж ахуйн хоршоог удирдах нь” сургалтыг тогтмол зохион байгуулдаг болох. Мөн “Манай хоршоо” сургалт явуулах эрх бүхий мастер сургагч багш нарын үндэсний нөөцийг бүрдүүлэх.
 - в. Хөдөлмөрийн яамнаас “Манай хоршоо” сургалтыг “Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд түгээх боломжийг эрэлхийлэх. Энэ тохиолдолд аймаг бүрт наад зах нь “Манай хоршоо” сургалтын нэг сургагч багш байхаар тооцож, МХААХҮХ-ноос сургагч багш нарыг бэлтгэх шаардлага тулгарна. Өнөөдрийн байдлаар ХААХҮХ-ны 15 аймгийн салбар тус бүрээс нэг хүнийг сургагч багшаар бэлтгээд байна.
- Малчдын хоршоо хөгжлийнхөө эхэн үе шатанд хөрөнгө санхүүгийн эх үүсвэрээс хүртэх боломж хомс байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна. Тиймээс:
 - а. Одоо үйл ажиллагаа явуулж буй малчдын хоршоодыг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн “Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн зорилтот бүлэгт хамруулах замаар “Зээлийн батлан даалтын сан”-аас баталгаа гаргуулах боломжийг нээж өгөх асуудлыг авч үзэх нь зүйтэй.
 - б. Малчид, малчдын хоршоодын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор “Сум хөгжүүлэх сан”-д хуваарилах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх.
 - в. Малчин өрхийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарч байгаатай адил малчдын хоршооны зээл, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарах.
- Засгийн газар болон МХААХҮХ малчдын хоршоог хөгжүүлэх бодлого, дэмжлэгээ боловсронгуй болгоход анхаарах шаардлагатай. Үүнд:
 - а. МХААХҮХ-ноос (“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийн 2 дугаар үе шатны хүрээнд) МХХСМТ-тэй хамтран зохион байгуулах “Манай хоршоо – Хөдөө аж ахуйн хоршоог удирдах нь” сургалтад Засгийн газраас жил бүр санхүүжилт олгодог болох.
 - б. МХААХҮХ-ноос малчдын хоршооны хөгжлийг чиглүүлэх, дэмжих зорилгоор орчин үеийн малчдын хоршооны загварыг боловсруулж, батлах.
 - в. МАПС төслийн туршилтын хөтөлбөрт хамрагдсан 6 хоршоог загвар болгон оролцуулах замаар МХААХҮХ-ноос малчдын сонгогдсон хоршоодод зорилтот дэмжлэг үзүүлэх. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлснээр МХААХҮХ ч, сонгогдсон хоршоод ч ялгаагүй үнэтэй туршлага хуримтлуулж, цаашид илүү олон малчдын хоршоонд үр шимээ өгөх боломжтой болно.
 - г. Малчдын хоршоодын бизнесийг хөгжүүлэх, чадавхжуулах стратегийг “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийн дараагийн үе шатыг төлөвлөх үед (2017 оноос хойш) тодорхой тусгах шаардлагатай. Орчин үеийн хөдөө аж ахуйн хоршоог хөгжүүлэхийн тулд дэвшүүлэх зорилт, хүрэх үр дүнгээ тодорхой болгож, зохистой нөөц хуваарилах шаардлагатай. Тэдгээр зорилтын нэг нь хувийн хэвшил ба малчдын хоршоодын хоорондох түншлэлийг бэхжүүлж, малчдын хоршоог нэмүү өртгийн сүлжээний чухал тоглогч болгоход чиглэвэл зохино.

Малчдын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх

- Малчид сайн дурын нийгмийн даатгал, эрүүл мэндийн албан журмын даатгалд хамрагдаж, шимтгэлээ тогтмол, тасралтгүй төлөх боломжийг бүрдүүлэх чиглэлд холбогдох журмыг уян хатан болгох хэрэгтэй. 2015 онд энэ чиглэлээр тодорхой ахиц дэвшил гарсан ч цаашид илүү сайжруулах шаардлагатай.
- Шимтгэл хураалтыг илүү уян хатан зохион байгуулах нь зүйтэй. Малчдын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлж, шимтгэл төлөлтийг тогтмолжуулахын тулд НДЕГ-

аас малчдын хоршоодтой шинэлэг байдлаар хамтарч ажиллах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй. Энэхүү зөвлөмж нь цаашид малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчдыг нийгмийн даатгалд албан журмаар хамруулах бодлого хэрэгжих үед ч ач холбогдолтой юм.

- НДЕГ нь нийгмийн даатгалын талаарх малчдын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн сурталчилгаагаа орон нутгийн засаг захиргаа, малчдын хоршоо, Хөдөлмөрийн хэлтсүүдтэй хамтран боломжит бүх суваг, тухайлбал, нэг цэгийн үйлчилгээ зэргийг ашиглан идэвх санаачилгатай, тасралтгүй зохион байгуулах нь зүйтэй.
- НДЕГ нь малчид, залуучууд зэрэг тодорхой зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаагаа өргөжүүлэхдээ үйлчлүүлэгч-төвтэй арга барилыг нэвтрүүлэх, үүний тулд нийгмийн даатгалын ажилтнуудын ойлголт чадавхийг дээшлүүлж, хэрэглэгчдэд хялбар арга хэрэгсэл ашиглах нь зүйтэй.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудын чадавхийг бэхжүүлж, орон нутгийн холбогдох талуудын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтыг сайжруулах

- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлэхдээ цогц арга барилаар хандах, зорилтот бүлгүүдийн өмнө тулгарч буй олон асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангах шаардлага тулгамдаж байна. Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулахдаа саяхан нэгдэн орсон ОУХБ-ын холбогдох конвенциудыг харгалзан үйл ажиллагааны журам, сургалтын материалаа боловсруулж, албан хаагчдаа чадавхжуулах нь зүйтэй.
- Өөр өөр яаманд харьяалагддаг нэлээд олон төрийн албан хаагч сумын түвшинд ажиллаж байна. Үүнд: Мал эмнэлэг, үржлийн тасагт 3 албан хаагч (Хүнс, хөдөө аж ахуйн яаманд), Насан туршийн боловсролын төвийн арга зүйч (Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд), хөдөлмөр эрхлэлт буюу жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн (Хөдөлмөрийн яам, эсвэл Аж үйлдвэрийн яаманд), нийгмийн халамжийн ажилтан болон нийгмийн даатгалын байцаагч (Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд), багийн Засаг дарга гэх мэт. Хэрэв эдгээр ажилтнуудын чиг үүрэг, үйл ажиллагааг нэгдмэл зорилго, түншлэлд тулгуурлан зохицуулж чадвал төрийн бодлого, хөтөлбөрийн үр дүнг сайжруулах боломжтой. Ийм хамтын ажиллагаа нь малчдад ч гэсэн эерэгээр тусч, хөгжил дэвшилд тэдний оролцоо чухал гэдгийг мэдрүүлэх болно.
- Аймаг, үндэсний түвшинд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдааг хангах, улмаар төрийн бус байгууллага, холбоод, сургалт, судалгааны байгууллагуудтай түншлэлийн зарчмаар хамтран ажиллаж, төрийн бодлого, үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулах нь зүйтэй.

ОУХБ/Япон Улсын Засгийн газрын хамтарсан төслөөс хэрэгжүүлсэн туршилтын хөтөлбөрт хамрагдсан орон нутгийн талууд болон малчдад өгөх зөвлөмж

- Сумын түвшинд бий болсон бизнесийн зөвлөх үйлчилгээг тогтвортой үргэлжлүүлэх, бэхжүүлэх
- Залуу малчдын бие даасан сургалтын үр дүнд тавих хяналтыг үргэлжлүүлж, Мал эмнэлэг, үржлийн тасгийн албан хаагчдын тусламжтайгаар шаардлагатай дэмжлэг үзүүлэх
- Сургагч багшаар бэлтгэгдсэн Насан туршийн боловсролын төвийн арга зүйчийн тусламжтайгаар ур чадвар хөгжүүлэх сургалтыг зохион байгуулж, залуу малчид, хоршооны гишүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх
- Нийгмийн даатгалын ач холбогдлын талаар малчдын мэдлэгийг сайжруулж, нийгмийн даатгалд хамрагдахыг дэмжих
- МХААХҮХ-той хамтарч малчдын хоршооны хөгжилд дэмжлэг үзүүлэх
- “Манай хоршоо” сургалтаар олж авсан мэдлэг, чадвартаа тулгуурлан малчдын хоршоодын дарга, гишүүд хоршооныхоо хөгжлийн алсын хараа, стратегиа боловсронгуй болгох, гишүүдэд үзүүлэх үйлчилгээнийхээ нэр төрлийг олшруулах, гишүүдийнхээ итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх

ХАВСРАЛТ 1. ХӨДӨЛМӨРИЙН ЯАМНААС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ЗАРИМ ХӨТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр нь богд шилжүүлснээр 150 хүртэл толгой малтай⁸ ядуу малчин өрхөд (35 хүртэлх насны 2-оос доошгүй гишүүнтэй өрх⁹) чиглэгдсэн. Сумын Амьжиргааг дэмжих зөвлөл хамрагдах өрхийг сонгоно. Тус хөтөлбөрт хамрагдах малчин өрх 100 хүртэл толгой малтай бол 5 сая төгрөг, 100-150 хүртэл толгой малтай бол 4 сая төгрөгийн мал худалдан авахад дэмжлэг үзүүлдэг. Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс мал худалдаж авах ажлыг зохион байгуулж, өрхийн тэргүүнтэй гэрээ байгуулдаг. Малчин Хөдөлмөрийн хэлтэстэй тохиролцож тогтоосон хуваарийн дагуу энэхүү хүүгүй санхүүгийн дэмжлэгийн 50 хувийг 2 жилийн дотор төлөх үүрэгтэй.

Хөтөлбөрт хамрагдах хугацаанд малчид аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ажиллагааны шавь болон зайны сургалтад хамрагдах боломжтой. Мөн малын хашаа хороогоо засаж сэлбэх буюу өвөлжилтийн бэлтгэл хангахад дэмжлэг тусламж авч болно (энэхүү арга хэмжээнд малжуулах арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн 5 хүртэл хувийг ашиглаж болно). Хэрэв 50 хүртэл толгой малтай өрх малжуулах арга хэмжээнд хамрагдах бол дадлага, туршлагатай дадлагажуулагч малчныг томилж, сургалтын зардлыг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаас санхүүжүүлнэ. Одоогоор тус хөтөлбөрт хамрагдаж буй малчдад зориулсан сургалтад ямар нэгэн модулийг онцолж сонгоогүй байна. Хөтөлбөрт хамрагдаж буй малчдын хувьд аж ахуй эрхлэх буюу бизнесийн сургалтад хамрагдах боломж хязгаарлагдмал байгаа аж. Хөдөлмөрийн хэлтсээс зохион байгуулж буй үйл ажиллагаа нь ерөнхийдөө хөтөлбөрт хамрагдсан малчдыг орон нутгийн сайн малчидтай уулзуулж туршлага судлуулах, өөр аймаг суманд танилцах аялал хийлгэх хүрээнд л байна.

Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр нь ажил хайж буй иргэд, ажилгүйдэлд өртөж болзошгүй (тухайлбал, хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл авсан, эрхэлж буй аж ахуй нь эрсдэлд орсон) иргэд, шинэ ур чадвар эзэмших болон ур чадвараа дээшлүүлэх сонирхолтой хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд чиглэсэн. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад ажил олгогчдын хүсэлтээр зохион байгуулдаг үйлдвэрлэл дээрх сургалт, мэргэжлийн сургалт, давтан сургалт (ажилгүйдэлд өртөж болзошгүй байгаа ажилтнуудад зориулсан) болон явуулын сургалт (Хөдөлмөрийн хэлтсийн хүсэлтээр Улаанбаатарт байрладаг сургалтын байгууллага аймагт очиж сургалт зохион байгуулдаг) багтдаг.

Мэргэжлийн сургалтыг 1-6 долоо хоног үргэлжлэх чадамжид суурилсан хөтөлбөрөөр явуулдаг. Мэргэжлийн болон давтан сургалт явуулах мэргэжлийн чиглэл, нэг суралцагчид ногдох болон нийт зардлын дээд хэмжээг Хөдөлмөрийн яамнаас жил бүр батлан гаргадаг. Жишээлбэл, 2016 оны жагсаалтанд малчны сургалт, сүү цагаан идээ, мах, арьс шир боловсруулах сургалтууд багтжээ.

Мэргэжлийн сургалтад хамрагдсан нийт иргэдийн 70 хувийг сургалтын дараа хувиараа, эсвэл цалинтай хөдөлмөр эрхлүүлэх, ажлын байрыг нь хадгалах зорилт тавьдаг. Тиймээс аймгийн Хөдөлмөрийн хэлтсүүд мэргэжлийн сургалтыг ажил олгогчдын эрэлтэд тулгуурлан зохион байгуулах нь түгээмэл ажиглагддаг.

Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр нь хувиараа хөдөлмөр эрхлэгч,

⁸ Малчдын амьжиргааны байдлыг тодорхойлохдоо малын тоог богд шилжүүлэн тооцно.

⁹ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт заасан энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу Хөдөлмөрийн хэлтэс уг хөтөлбөрт эхнэр, нөхөр хоёул 35-аас доош настай өрхийг сонгон хамруулж байна.

албан бус салбарт ажиллагч болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдэд чиглэсэн. Тус хөтөлбөр нь сургалт, санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл, борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлж хоршоо, нөхөрлөл байгуулах үйл ажиллагаанд тусалдаг. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид жилийн 7.2 хувийн хүүтэй 5 сая хүртэл (хоршоо, нөхөрлөл байгуулах иргэнд 10 сая хүртэл) төгрөгийн зээлийг 24 хүртэл сарын хугацаагаар олгодог. Аж ахуй эрхлэлтийн сургалт нь БЭХ хөтөлбөр, хоршоо, нөхөрлөл байгуулах, санхүүгийн тайлан тооцоо гаргах, маркетингийн зэрэг үр шим хүртэгчдийн хэрэгцээнд нийцсэн олон төрлийн модультай. Гэвч энэхүү хөтөлбөр нь нэгэнт хоршоо байгуулсан иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр дэмжлэг үзүүлдэггүй.

ХАВСРАЛТ 2. ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУАНЛИ

Туршилтын хөтөлбөрийн үйл ажиллагааг дараах дарааллаар хэрэгжүүлжээ:

- Аймаг бүрт “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн ажлын хэсэг” байгуулсан (2014 оны 6-р сар).
- Зорилтот сумдад нийгэм, эдийн засгийн үнэлгээ хийсэн (2014 оны 6-9-р сар).
- Сонгогдсон аймаг бүрт орон нутгийн холбогдох талуудын уулзалт семинар зохион байгуулж, туршилтын хөтөлбөрийн тэргүүлэх стратегийг тодорхойлж (2015 оны 3-р сар), тус стратегийг төслийн Удирдах хороогоор батлуулсан (2015 оны 4-р сар).
- БЭХ хөтөлбөрийн сургагч багшийн сургалт зохион байгуулсан (2015 оны 6-р сар).
- Хоёр суманд хөтөлбөрт хамрагдах хоршоод болон малчдыг тодорхойлж, туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан (2015 оны 7-р сар).
- Хоёр суманд хөтөлбөрт хамрагдаж буй залуучууд, хоршооны гишүүдийг бизнес эрхлэх сургалтад хамруулсан (2015 оны 7-р сараас 2016 оны 5-р сар).
- “Орон нутгийн бизнесийн хөгжил” бие даан суралцах гарын авлага боловсруулж, хэвлэн түгээсэн (2014 оны 10-р сараас 2015 оны 3-р сар).
- Хөтөлбөрт хамрагдагсдын бэлчээрийн мал аж ахуйн арга ажиллагааны талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “XXI зууны малчин”¹⁰ бие даан суралцах гарын авлагын есөн модулийг (туршилтын хөтөлбөрөөс дахин хэвлүүлж) түгээсэн (2015 оны 7-р сараас 2016 оны 5-р сар).
- Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлд ажиллах мэдлэг, чадавхийг дээшлүүлэх сургалтыг сонгогдсон 2 аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн ажилтнуудад зохион байгуулсан (2014 оны 10-р сар, 2015 оны 9-р сар).
- Сонгогдсон хоёр аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн ажилтнуудад хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх чадавхийг сайжруулах сургалт зохион байгуулсан (2015 оны 10-р сар).
- Хоёр сумаас тус бүр 40-50 малчныг сүү, ноос, арьс шир, мах боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх ур чадвар хөгжүүлэх 4 төрлийн сургалтад хамруулсан (2015 оны 6-12-р сар).
- Ур чадварын 4 чиглэлээр бие даан суралцах, хэрэглэхэд хялбар гарын авлага боловсруулж, хэвлүүлэн түгээсэн (2015 оны 6-р сараас 2016 оны 5-р сар) нь “XXI зууны малчин” бие даан суралцах модулийг улам баяжуулсан.
- Сум бүрт бизнесийн зөвлөх үйлчилгээг бий болгосон (2015 оны 11-р сараас 2016 оны 5-р сар).
- Нийгмийн даатгалын тогтолцооны талаар малчдад зориулсан хэрэглэхэд хялбар гарын авлага боловсруулж, хэвлүүлэн түгээсэн (2015 оны 9-р сараас 2016 оны 5-р сар).
- Бие даан суралцах, ур чадвараа сайжруулахад нь зориулж боловсруулсан бүх гарын авлагыг залуу малчид, малчдын хоршооны бусад гишүүдэд тараасан (2015 оны 6-р сараас 2016 оны 5-р сар).
- ОУХБ-ын “Манай хоршоо” сургалтын хөтөлбөрийг орчуулж, Монгол орны нөхцөлд нийцүүлэн боловсруулсан (2016 оны 2-6-р сар).
- ОУХБ-ын “Манай хоршоо” хөтөлбөрийн сургагч багшийн сургалтыг олон улсын сургагч багш зохион байгуулсан (2016.05.9–13).
- Орон нутагт шинээр бэлтгэгдсэн сургагч багш туршилтын хөтөлбөрт сонгогдсон хоршооны менежер, гишүүдэд сургалт зохион байгуулсан (2016.05.16–20).

¹⁰ Малчдад нэн шаардлагатай мэдлэг, чадварыг хөгжүүлэх зорилготой 9 модуль бүхий сургалтын энэхүү багцыг 2012-2013 онд ОУХБ-ын “Хөдөөгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргажээ.